

MONGOLIAN ECONOMY

2015 оны 09 сар. № 16 (095)
www.mongolianeconomy.mn

ЭДИЙН ЗАСАГ

Б.Нэмэхбаатар: "MCS" бол монголчуудын үндэсний баялаг


ОНЦЛОХ

Хөрөнгө оруулалтын өлгий нутаг

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монголд орж ирсэн шалтгаан нь хямрал

Яагаад Монгол...



8 165 8000 167941 6

The Economist

Дэлхийд алдартай сэтгүүлд
сурталчилгаа байршуулах
ховорхон боломж

INCLUDES
FREE DIGITAL ACC

The World in 2015



The Economist сэтгүүлийн жилийн IN WORLD-2016 дугаарыг **Mongolian Economy** сэтгүүлд
Монгол дахь албан ёсны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэн гаргах гэж байна.
2016.01 сард танд хүрнэ
Утас: +976 94092904
70115476
И-мэйл: Marketing@mongolianeconomy.mn

US\$11.95 C\$11.95

DISPLAY UNTIL 2/28/2015 55



0 09281 02316



MONGOLIAN ECONOMY



ГҮНЗГИЙ МЭД

Дөрөвдүгээр улирлын захиалга эхэллээ

Утас: 94092904 70115476

НЭГ ДУГААР	15,000₮
УЛИРАЛ /6 ДУГААР/	90,000₮
ХАГАС ЖИЛ /12 ДУГААР/	180,000₮
ЖИЛ /24 ДУГААР/	360,000₮

180,000₮

Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:

Д.БЭХБАЯР / 9999-4248

Үүсгэн байгуулагч, Орлогч эрхлэгч:

И.ОТГОНЖАРГАЛ / 8800-6228

Сэтгүүлийн редактор:

Б.ҮҮРИЙНТУЯА

Англи хэлний редактор:

О.ТҮВШИН

Вэб редактор:

Б.ЭНХЦЭЦЭГ

Сэтгүүлчид:

А.БҮРЭНЖАРГАЛ

Г.ОРХОН

Ц.ЭЛБЭГСАЙХАН

Дизайнер:

Б.СЭР-ОД

Маркетингийн менежер:

Д.БАРИАНЖАВ / 9409 2904

**РЕДАКЦИД
ЗАХИАЛБАЛ
ХҮРГЭЛТ
ҮНЭГҮЙ**

ГҮНЗГИЙ МЭД



ХАЯГ

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг.

I хороо, Энхтайвны өргөн чөлөө.

Экспресс тауэр. 1101 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан,

ш/ х-2762

WWW.MONGOLIANECONOMY.MN

INFO@MONGOLIANECONOMY.MN

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

“Улаанбаатар Принт” ХХК-д хэвлэв

WWW.UVPRINT.MN

Борлуулах цэгүүд:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетин бүх салбар

“Макс” супермаркетин бүх салбар

“Фреско” супермаркет

ВТСІ супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн

“GRAND PLAZA”

“METRO MALL”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр

“Мах mall” дэх салбарууд

ЭДИЙН ЗАСАГ

8 ПОПУЛИЗМГҮЙ УУЛ УУРХАЙН ТӨЛӨӨ

10 Б.НЭМЭХБААТАР: "MCS" БОЛ МОНГОЛЧУУДЫН ҮНДЭСНИЙ БАЯЛАГ

13 ҮЙЛДВЭРЖИЛТИЙН АНХНЫ АЛХАМ

14 МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ЗӨВЛӨЛ

16 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БОДИТ ҮЛГЭР ЖИШЭЭ

17 ЭРЧИЙГ АВСАН ЭРЧИМ БОНД

18 СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

ОНЦЛОХ

20 ЯГ ОДОО

22 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨЛГИЙ

25 ХӨГЖИЖ БУЙ ОРНУУД ДЭЛХИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 50 ХУВИЙГ ТАТДАГ

27 МОНГОЛЫГ СОНГОХ ЁСТОЙ ЕСӨН ШАЛТГААН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

29 БАЯЛАГ ХАДГАЛАГЧИД

30 МОНГОЛД ОРЖ ИРСЭН ШАЛТГААН НЬ ХЯМРАЛ

31 МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН ҮНЭЛГЭЭ

33 СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

34 ЭСТОНИ, ЯМАЙК + АФРИК ба БНХАУ

36 МОНГОЛЫН БИЗНЕС БОЛОМЖУУД

38 ТОГТВОРЖУУЛАХ ГЭРЧИЛГЭЭ

39 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЧ



Зүүн болон Зүүн өмнөд Ази руу чиглэх хөрөнгө оруулалтын урсгал 10 хувиар өсч 381 тэрбум ам.долларт хүрчээ. Харин дэлхий нийтийн Хөрөнгө оруулалтын урсгалыг авч үзвэл өнгөрсөн онд 14 хувиар буурчээ. 2013 онд 14.7 их наяд байсан урсгал 1.23 их наяд болжээ гэсэн үг.



Ард иргэд нь орлогогүй болчихоор бүх л компанийн борлуулалт нь багасч, зээлээ төлж чадахгүй болж ирлээ. Зардлаа багасгаж, шаардлагагүй төслөө зогсоож байна. Ажлын байрыг хадгалахад анхаарч, ашиг олохдоо гол биш бүтцээ хадгалж хямралыг давж гарах чиглэл баримталж байна.



Дэлхийн хөрөнгө оруулалтын тайланд 2014 онд дэлхийн хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалт 16 хувь буюу 1,23 триллион ам.доллараар буурсан бөгөөд үүний цаад шалтгаан нь дэлхийн эдийн засгийн өсөлт удаашрах, улс орнуудын хөрөнгө оруулалтын бодлого тодорхой бус байх, эцэст нь геополитикийн шинж чанартай асуудлууд гэсэн үндсэн гурван шалтгааныг тус тайланд нэрлэжээ байгаа.

ТОГТВОРЖУУЛАХ ГЭРЧИЛГЭЭ



“Алтайн хүдэр”, “Скай Резорт” компаниуд анхны Тогтворжуулах гэрчилгээгээ өнгөрсөн сарын 21-нд авлаа. Таяннуурын төмрийн хүдрийн ордод олборлолт явуулдаг “Алтайн хүдэр” ХХК нийт 279.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх бөгөөд 11 жилийн хугацаатай тогтворжуулах гэрчилгээ авчээ. Мөн 46.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай цанын бааз, гольфын талбайн төслөөр “Скай Резорт” ХХК найман жилийн хугацаатай тогтворжуулах гэрчилгээ авсан байна. Хөрөнгө оруулалтын хуульд заасан тодорхой шалгууруудыг хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд үг гэрчилгээг олгож, ААНОАТ, НӨАТ, АМНАТ, гаалийн албан татварыг 5-24 жилийн хугацаанд хувь, хэмжээг нь тогтвортой байлгах нөхцөл бүрдэх аж. Үг гэрчилгээг Хөрөнгө оруулалтын газрын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн дүгнэлтээр олгож буй.

ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Монгол Улс дэлхийн 61 улсыг харьцуулсан “Дэлхийн өрсөлдөх

IMD WORLD
COMPETITIVENESS
YEARBOOK



чадварын тайлан 2015”-д энэ жилээс хамрагдаж эхэллээ. Өмнөх жилүүдэд хамгийн эхэнд буй Сингапур улсын оноог 100 гэж тооцоод бусад улсад тархаадаг байсан бол энэ жилээс эхлэн АНУ-ын оноог 100 (АНУ 61 улсыг харьцуулсан тайланг тэргүүлж, удаах

байруудад Швейцарь, Сингапур улсууд орсон) гэж тооцсон. Монгол Улсын хувьд албан ёсоор тус тайланд багтдаггүй байсан ч оноогоор эрэмблэгдэж байсан байна. Анх 2010 онд Монгол Улсын оноо 23.9 байсан бол 2011 онд 27.8, 2012 онд 39.3, 2013 онд 62.3 болж 2010 оноос гурав дахин өссөн. Энэ нь манай улсын өрсөлдөх чадвар сайжирч байгааг харуулж байгаа юм. Харин 2014 оны хувьд өрсөлдөх чадварын оноо 44.5 болж буурсан байна. Үг тайланд Монгол Улс 61 орноос 57 дугаарт (Хорват, Аргентин, Украин, Венесуэл улсуудын өмнө) эрэмблэгдэж байж. Хэдийгээр ийнхүү хойгуур байгаа ч энэхүү тайланд орж байгаа нь том амжилт гэдгийг Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварын судалгаанд туршжээ. Дээр дурдсан өрсөлдөх чадварыг хэмждэг дөрвөн хүчин зүйлийн хувьд өнгөрсөн жилээс эдийн засгийн тамир тэнхээ үзүүлэлт нэг байраар ахиж 14 дүгээрт, засаглалын үр ашиг үзүүлэлт хоёр байраар ахиж 13 дугаарт эрэмблэгдсэн бол бизнесийн байгууллагын ашигт ажиллагаа үзүүлэлт нэг байраар ухарч 13 дугаарт, харин дэд бүтэц 14 дүгээрт эрэмблэгдсэн хэвээр байна.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Жилд нэг сая тонн цемент үйлдвэрлэх



хүчин чадалтай үндэсний үйлдвэр өнгөрсөн сарын 13-нд Дорноговь аймгийн Өргөн суманд нээлтээ хийлээ. Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Говь нутагт их бүтээн байгуулалт өрнөж, үндэсний нэгэн шинэ үйлдвэр үүдээ нээлээ. Үндэсний үйлдвэрлэгчид дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаад зогсохгүй цаашид Европ стандартад нийцсэн өндөр чанартай цементийг экспортод гаргах цаг удахгүй гэдэгт итгэлтэй байна” гэсэн юм. Ингэснээр Монгол Улс жилд гурван сая гаруй тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай болжээ. Манай улсын жилийн хэрэгцээ 2013-2014 онд хоёр сая гаруй тоннд хүрсэн байдаг. Энэ онд цементийн хэрэглээний дийлэнхийг үндэсний үйлдвэрүүд хангасан.

Цаашид 2016 оноос дотоодынхоо хэрэгцээг бүрэн хангах боломж бүрдэх аж. Иймээс Аж үйлдвэрийн яамны зүгээс импортын татварыг төрийн бодлогоор зохицуулж, үндэсний үйлдвэрүүдээ дэмжиж, дотоодынхоо зах зээлийг хамгаалах бодлого баримтлахаа дуулгав. Одоогоос 10-аад жилийн өмнө буюу 2006 онд “Монполимет” группын эхлүүлсэн төсөл амжилттай хэрэгжиж Европын стандарт, шаардлагад нийцсэн орчин үеийн дэвшилтэт, хуурай аргын технологитой, байгаль орчинд ээлтэй анхны эко цементийн үйлдвэр байгуулсан нь энэ аж.

ДААТГАЛ

Монгол Улстай нийгмийн хамгааллын



салбарт хамтран ажиллах хэлэлцээргүй орнуудад оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах нөхцөл бүрджээ. Нийгмийн даатгалын шимтгэлийг шилжүүлэх, хүлээн авах үйлчилгээг цахимаар хийх ажлыг Нийгмийн даатгалын байгууллага зохион байгуулж Төрийн банктай хамтран хэрэгжүүлэх ажил хэрэгжиж байгаа юм. Одоогоор шинээр программ боловсруулах ажил дууссан байна.

Гадаадад байгаа Монголчууд маань эх орондоо эргэн ирэх нийгмийн баталгаагаар хангах зорилгоор сайн дурын даатгалд хамрагдах хүсэл сонирхол их байдаг. Гэвч өөрсдөө шимтгэлээ төлөх боломжгүй, өөрийгөө төлөөлсөн хэн нэгнээр дамжуулан шимтгэл төлөх явцад хугацаа хоцроох, тасалдуулах, шимтгэл төлөх хувь хэмжээг нь өөрсдийн дураар бууруулах гэх мэт төвөгтэй байдал үүсдэг байсан юм.

Тэгвэл сайн дурын даатгалын гэрээг цахимаар үйлдэж, шимтгэлээ цахимаар төлөх боломжийг бий болгосноор асуудал цэгцэрч, сайн дураар даатгуулагчдын тоо ч өснө гэсэн хүлээлт байна. Түүнчлэн шимтгэл төлөх хугацаа, нөхцөлийг уян хатан байхаар зохицуулж өгч буйгаараа онцлог. ■

ДЭЛХИЙД

ОЛОН УЛСЫН ХУВЬЦАА
УНАЖ БАЙНА

Бүх томоохон хөрөнгийн биржийн индексүүд унаж эхэлжээ. Энэ нь Хятад улсын хувьцааг огцом худалдаж эхэлсэнтэй холбоотой үймээн бөгөөд Хятадын хэвлэл мэдээллийнхэн Хар Даваа гариг хэмээн нэрийдэж байна. Лондонгийн "FTSE 100" индекс 73,75 тэрбум фунт стерлинг алдаж 4.6 хувийн бууралттайгаар өдрийг хаасан байна. Уолл Стритийн "Dow Jones" 16,000-гаас доош унасны эцэст бага зэрэг сэргэсэн нь 2014 оны хоёрдугаар сараас хойш үзүүлээгүй доогуур үзүүлэлт юм. Харин "Shanghai Composite" 8.5 хувиар унасан нь 2007 оноос хойш үзүүлсэн хамгийн муу үзүүлэлт аж. Нефтийн үнэ 2009 оны гуравдугаар сараас хойшхи хамгийн доод түвшинд хүрч өдрийг 42.61 ам.доллараар хаасан байна. Хятадын Төвбанк Хар Даваа гаригаас хоёр долоо хоногийн өмнө экспорт нэмэгдүүлэх зорилгоор юанийн ханшийг бууруулсан нь хөрөнгө оруулагчдад Хятадын удааширч буй өсөлт таамаглаж байснаас муудах нь гэх ойлголтыг төрүүлсэн аж. Бодлого боловсруулагчид уг асуудлыг зогсоохын тулд Хятадын төрийн тэтгэврийн сангийн 30 хувийг зах зээлд хөрөнгө оруулах шийдвэр гаргасан хэдий ч энэ нь төдийлөн нэмэр болсонгүй. БНХАУ-ын эрэлт хэрэгцээнд тулгуурлан хөрөнгө оруулагчид хөрөнгийн зах зээлд итгүүлэх оролдлогыг удаа дараа амжилтгүй хийсэн Хятадын засгийн дараагийн алхмыг л хүлээж сууна. Хар Даваа гаригийн дараах өдөр Хятадын хувьцаа үргэлжлэн хурдацтай унасаар байсан ч Европ болон АНУ-ын хувьцаа аажмаар сэргэж байна.

ГАЗРЫН ТОС

Өнгөрсөн оны мөн үеэс хойш бараг 60 хувиар буурсан соёл иргэншилт амьдралын эх булаг болох нефтийн үнэ ойрын хугацаанд нэмэгдэх шинж тэмдэггүй байна. Наймдугаар сард

Иракт ширүүн жагсаал болж жагсагчид засгийн газрыг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангаж чадахгүй байгаад бухимдлаа илэрхийлж мөн тэдний амласан газрын тосны мөнгө яасан болохыг мэдэгдэхийг шаардсан аж. Рублийн ханшийн бууралт, мөн эдийн засгийн хориг арга хэмжээ зэргээс хамаарч ОХУ-ын хэрэглэгчид цалингийнхаа дийлэнхийг хэрэгцээндээ зарцуулах болжээ. Газрын тосноос хамааралтай улс орнууд улс төрийн эмх замбараагүй байдал үүсэх вий гэсэн айдастай байна. БНХАУ-д болсон эдийн засгийн гэнэтийн цочрол зэргээс шалтгаалан газрын тосны үнэ өсөх магадлал тун бага төдийгүй АНУ газрын тосыг дотооддоо илүүтэй үйлдвэрлэж, сэргээгдэх эрчим хүчний салбар илүүтэй хөрөнгө оруулах болсон байна. ОПЕК-ийн гишүүн орнууд газрын тосны үйлдвэрлэлийг бууруулах саналыг Саудчууд эсэргүүцсэн нь магадгүй их зардалтай ханган нийлүүлэгчдийг хүчээр шахах зорилготой байх магадлалтай. Газрын тосны үйлдвэрлэгчид зах зээлийн өрсөлдөөнд үлдэхийн тулд үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхээс өөр ямар ч сонголтгүй болж байгаа юм. Исламын улс террорист бүлэглэлийн халдлагад өртөж буй Ирак улс хүртэл үйлдвэрлэлээ жилийн эхээс эхлэн ойролцоогоор 20 хувиар нэмсэн юм. Удаан хугацааны турш газрын тосны үнэ доогуур байснаар засгийн газрын төсөвт том цохилт болж, зардлаа багасгах эсвэл өр зээлээ нэмэгдүүлэхэд хүргэж байгаа аж. Арванхоёрдугаар сарын 4-нд болох дараагийн ОПЕК-ийн уулзалт ширүүхэн болох хандлагатай байна.

ИХ БРИТАНИ ТЕГЕРАНД ЭСЯ-АА
ДАХИН НЭЭНЭ

Нэгдсэн Вант Улс Тегеран дахь ЭСЯ-аа дахин нээхээр боллоо. 2011 онд Ираны цөмийн хөтөлбөрийн улмаас авсан эдийн засгийн хориг арга хэмжээг эсэргүүцсэн жагсагчид Нэгдсэн Вант Улсын Тегеран дахь ЭСЯ-ны байрыг сүйтгэсэн юм. Гэсэн хэдий ч НҮБ-ийн Аюулгүйн зөвлөл болон Герман улс Ирантай олон жил эрчимтэй хэлэлцэний эцэст долдугаар сард хэлэлцээрт хүрч чадсан. Иран гэрээнд тусгасан заалтуудыг зөвшөөрч, мөн Вена хотод

төвтэй Олон улсын атомын эрчим хүчний агентлагийн мэргэжилтнүүд хяналт хийсний дараагаар Ираны томоохон газрын тос болон санхүүгийн хориг арга хэмжээг цуцлах аж. Европ, ОХУ болон БНХАУ-ын компаниуд Ирантай бизнесийн харилцаагаа сэргээх чин хүсэлтэй байгаа ажээ.

ЦАГААЧЛАЛЫН ХЯМРАЛ



Францын Ерөнхийлөгч Франсуа Олланд болон Германы канцлер Ангела Меркель Европын холбооны цагаачлалын хямралын талаар нэгдсэн шийдвэрт хүрэхээр Берлин хотноо уулзлаа.

Ангела Меркель Европын холбооны гишүүн орнууд бүгд энэ бэрхшээлийг хамтран үүрэх ёстойг онцлон тэмдэглээд, тэр ч байтугай Газар дундын тэнгисийн өнцөг булангаас хууль бусаар шилжин ирж байгаа цагаачидтай тэмцэх Европын холбооны хяналттай бүртгэлийн төвийг Грек болон Италид байгуулж болох талаар дурьдав. Энэ уулзалт Македонийн засгийн газар улс төрийн орогнол хүсэгчдийг өөрийн хилээр нэвтрүүлэн Сербээр дамжин Унгарт хүрэх боломж олгосны дараагаар болсон юм.

Унгар улс нь Шенгений бүс нутагт ордог бөгөөд Шенгений бүс нутгийн 26 Европын орон хоороондоо ямар ч хилийн хяналтгүйгээр зорчдог аж. Унгарын Засгийн газар мэдэгдэхдээ шилжин суурьшигчдыг нэвтрүүлэхгүйн үүднээс Сербийн хилийн дагуу хашаа барина гэжээ. Сүүлийн жилүүдэд дүрвэгсэд болон улс төрийн орогнол хүсэгчид илүү сайхан амьдралыг хайж ЕХ-ны орнуудруу цувах болсон байна. Зарим шилжин суурьшигчид завиар ирдэг бөгөөд завины ачаалал хэтэрч олон хүний амь эрсдэсэн тохиолдол их гарч байгаа билээ. Харин зарим дүрвэгсэд Туркээс газраар Грек хүртэл явдаг аж. ■



ДИСКОВЕР МОНГОЛИА

Популизмгүй уул уурхайн төлөө

А.Билгүүн /Эдийн засагч/

Популизм Монголын эдийн засгийн “Толгойны өвчин” болоод нилээд хэдэн жил болж байна. Монголчуудын амьдрал уул уурхайн салбар, тэр дундаа уул уурхайн салбарт ордог гадаадын шууд хөрөнгө оруулалтаас зайлшгүй хамааралтай нь нэгэнт ойлгомжтой. Ойрын ирээдүйд ч бид уул уурхайн салбараас олох орлогоор л эдийн засгийн хөгжилд хүрэх нь гарцаагүй болчихлоо. Үүнийг тайлбарлахын тулд олон үгээр нуршихаас илүүтэйгээр баримт статистикаар тайлбарлавал илүү хялбар бөгөөд үнэмшилтэй болов уу. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос авсан доорхи мэдээлэлд тулгуурлан хэдэн баримт дурдъя.



Чин үнэн гэвэл дундаж монгол иргэн 10 жилийн өмнөхөөсөө харьцангуй чинээлэг амьдарч байгааг уул уурхайн салбартай холбож үзэхгүй байхын аргагүй. Энэхүү

эдийн засгийн үсрэнгүй хөгжил чухам Оюутолгойн хөрөнгө оруулалт орж ирсэн 2011 оноос эхлэлтэй гэж үзэж болно. Дээрхи үзүүлэнгээс харахад 2011 онд Монгол Улсад 5.9 их наяд төгрөгийн гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн нь манай эдийн засгийг тухайн жилдээ 17.3 хувь өсөхөд хүргэжээ. Мэдээж орд газрууд үнэтэй болохын хэрээр улстөрчид болон зарим нэг сонирхлын бүлгүүдийн явуулгаар гадаадын хөрөнгө оруулалтыг шахан зайлуулж эхэлснээр манай эдийн засгийн өсөлт огцом буурч, энэ жил бараг хасах үзүүлэлттэй гарах хандлагатай гэж зарим эдийн засагч айж байна.

Гэтэл улстөрчдийнхөөр бол уул уурхайн салбар баялаг бүтээдэггүй бөгөөд Монгол Улс өөр салбараар эдийн засгаа хөгжүүлэх боломжтой гэж үздэгээ нүүхгүй байна. Энэ бол бас л популизм... Бодит байдал нэг иймэрхүү.



Өнгөрсөн онд манай нийт экспортын 83 хувийг уул уурхайн салбарын эрдсийн бүтээгдэхүүн эзэлжээ. Одоогоор бидэнд дэлхийн зах зээлд зэс,алт,нүүрснээс өөр нийлүүлчихээр бүтээгдэхүүн байхгүй л байна. Гэтэл уул уурхайн салбарыг олон нийтэд харлуулж харагдуулахыг зоригчид өдгөө бүр УИХ гишүүд нь өөрсдөө болчихоод байхад манай эдийн засаг яаж өөдтэй байх юм бэ?

2011 оноос эхлэн Монголыг Азийн бар улс болох нь хэмээн дэлхий эндүүрч ирсэн шүү дээ.

10 жилийн өмнө 760 тэрбум байсан улсын нэгдсэн ДНБ ба төсвийн зардал




төсөв маань өнгөрсөн жил долоон их наяд (10 жилд 10 дахин өсөлт)болтлоо ихэсчээ. Энэ мөнгөнөөс монгол хүн бүр хүртсэн, засаг,төр маань баяжиж,олимп дэлхийгээс медал авсан тамирчиддаа насан туршид нь тэтгэмж өгөх хүртлээ хөрөнгөжсөн. Дээрхи төсвийн орлогын дийлэнхийг уул уурхайн компаниудын борлуулсан бүтээгдэхүүнээс татвар авч бүрдүүлсэн. Ийм байхад л уул уурхайн төслүүдийг ард түмэнд хүртээлгүй мэт тайлбарлаж байгаа нь бас л популизм.

Жирийн иргэдэд үнэхээр хүртээлгүй байсан уу гэвэл өрөөсгөл асуудал. Энэхүү нийтлэлийг уншиж суугаа та 2005 онд өнөөгийнхөөс баян байсан уу гэж асуувал бараг 90 хувь нь үгүй гэж хэлэх байх.

Ихэнх монгол уул уурхайн салбартай ямар нэгэн

Монголчуудын хадгаламж болон өр зээл



байдлаар холбогдолтой ажил эрхэлж байгаа. Уурхайд ажилладаггүй юмаа гэхэд уурхайд нийлүүлэлт хийдэг байгууллагуудад,эсвэл бүр уурхайгаас цалин авдаг иргэдэд бараа,үйлчилгээгээ зарж байгаа. Тиймдээ ч монголчуудын баян хэсэг нь банкинд хадгаламжтай,дунд давхрагынхан банкны зээлээр байр авах боломжтой болсон. 2005 онд бидэнд ийм боломж байсан уу?



Дээрхи статистик үзүүлэлтээс харж болно. 2011 онд нэг хүнд ногдох тээврийн хэрэгсэл 0.10 байсан бол 0.12 болж 20 хувь өссөн байна. Бид нийтээрээ хувийн машин унаж эхэлсэн, өнөөгийн гудамж талбайд багтахгүй олон машинтай болж,хувийн машин бол тансаг хэрэглээнээс илүү өдөр тутмын хэрэгцээ болж эхэлсэн. Ердөө 10 жилийн өмнө нэг хүнд 1.5 ам метр орон сууцны талбай ногдож байсан бол өнөөдөр 4.5 ам метр буюу гурав дахин их талбай ногдож байна.

Хэрэв бид уул уурхайн салбарыг огтхон ч ашигладаггүй байсан бол жилд нэг тэрбум хүрэхгүй ам.долларын экспортоотой,



эдийн засгийн өсөлт,хөгжил гэж яриад ч хэрэггүй,Азийн цээж дээрхи малчид л байх байлаа. Магадгүй манай улсыг онгон зэрлэгээрээ байдаг гэж гадаадын жуулчид олноор ирж үзэх байсан байх.

Өнөөгийн бидний амьдралыг уул уурхайгүйгээр төсөөлшгүй. Гэтэл популист улстөрчдийн явуулга,тэдний турхиралт Монголын хөгжлийн тулгуур болсон уул уурхайн салбарыг амь тавихад хүргээд байна. Бид төмөр зам барьж, нүүрсээ үнэд хүргэхийн оронд 21 мянган төгрөг тарааж найрласан. Бид Оюутолгойн далд уурхайг бариулахын оронд алаагүй баавгайн арьсыг булаалдаж гурван жил алдсан. Бид Мардайн ордыг булааж аваад 100 сая ам долларын өрөнд унасан. Бид Гацууртын ордыг хамгаалж буй нэрээр нинжа нараар сэглүүлж байна. Энэ бүхний эхлэл нь популизм,улс төрийн хийрхэл л байсан. 21 мянган төгрөг аваад нэг монгол хүн баяжсан уу. Ядуурал буурсан уу. Оюутолгойг зогсоогоод монголчуудад ямар сайн үр дүн авч ирэв. Гацууртын ордыг ашигласангүй гээд Хүннүгийн булш хаана байна. Энэ бүхний хариуцлагыг хэн хүлээх юм бэ? ■

Популизмгүй уул уурхайн төлөө. Та ямар бодолтой байна вэ?

Н.Алгаа: Монголын Уул уурхайн ассоциацийн ерөнхийлөгч



Гүйцэтгэх засаглал буюу бодлого боловсруулах, хууль санаачлах түвшний хүмүүс буруу шийдвэр гаргаснаас популизм үүсч байна. Үүнээс гарахын тулд олон талын судалгаанд үндэслэн мэдлэгт суурилсан шударга зарчим баримтлах ёстой. Зөвхөн Гацууртын төслийг гэхэд УИХ гурван удаа хэлэлцэж байна. Энэ бол дунд хэмжээний төдийгүй нэг компанийн л уул уурхайн төсөл. Гэтэл манай 76 улс төрч дунд хэмжээний компанийн ТУЗ-ийн хэмжээний асуудалтай ноцолдсоор байгаа нь өөрөө популизм. Үүнийг шийдвэрлэх ганц арга нь хууль гаргах процессийг шийдэх асуудал. Хууль гаргахад хэн санаачлах, ямар үндэслэлээр хэрхэн баталж байгаа тал дээр олон талын үзэл бодлыг тусгах хэрэгтэй. Үүний дараа олон талт бүлгүүдийн оролцоотойгоор хэлэлцүүлээд зөвшилцсөний үндсэн дээр шийдвэр гаргах хэрэгтэй. Олон талын оролцоо гэдэгт хамгийн багадаа гурван талын эрх ашиг хөндөгдөж байдаг. Төрийн эрх ашиг, бизнесийнхэн, нийгмийн бүлэг гэх мэт. Тиймээс энэ гурван талын эрх ашигт хамгийн ойртсон хэмжээнд зөвшилцөж байж 76 гишүүн аль зөв талд нь санал хурааж хариуцлагатай уул уурхай хөгжинө. Жилийн өмнө төрөөс эрдэс баялгын салбарт баримтлах бодлогын баримт бичгийг гаргасан. Хамгийн гол заалт бол төрийн оролцоог хязгаарлана гэсэн бий. Өдгөө түүнийг хэрэгжүүлэх л шаардлага тулгараад байна.

Ч.Хашчулуун: МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш доктор, профессор Уул уурхайгаас олж буй ашгаа ямар ч бодлогогүй нийтэд тарааж

өгөөд байвал утгагүй. Мөн цөөн хэдэн шийдвэр гаргах түвшний хүмүүс хувийн эрх ашгаа бодож бодлого тодорхойлж байгаа нь салбарын ирээдүйд хар толбо болж ирлээ. Хөрөнгө оруулалт татаж томоохон төслүүд амжилттай хэрэгжих хугацаа багагүй болсон. Гэсэн ч уул



уурхайн салбарын хөгжлийн бодлогыг албан ёсоор баталж түүндээ тууштай байж чадсангүй. Монгол Улсын уул уурхайн салбараас, ард түмний хүртэх үр өгөөжийг бодож ирээдүйтэй бодлого баримталж түүнийгээ хуулиар хамгаалж ажиллах хэрэгтэй. Шийдвэр гаргах түвшний хүмүүс эрх ашгаа хамгаалах, олсон мөнгийг нь цөөн хэдэн хүн хувааж идэх, өөрийн намын үйл ажиллагаанд зарцуулах бодлого баримталсаар байвал энэ салбар удалгүй баялаг ч үгүй бодлого ч үгүй болно

Д.Жаргалсайхан: “Эм Ай Эйч” группын Ерөнхийлөгч



Популизм уул уурхайн салбарыг хэрхэн сүйрүүлж байгааг бид харж байна. Иймээс тус салбарыг популист үйлдлээс хамгаалахын тулд шийдвэрлэх ямар арга зам байна түүнийг судлахаас л сайжруулах аргыг олох болов уу.

Уул уурхайн салбарын уналтад юу нөлөөлж байна, түүнийг шийдвэрлэсэн бусад орны туршлага, ямар бодлого баримталж буйг судалж олон талын оролцоог хангаж тэнцвэртэй бодлого баримтлах хэрэгтэй.

Б.Мандахбаяр: Уул уурхайн зураг төслийн “Дөрвөн талст” ХХК Захирал



Бидний хувьд томоохон төслүүдийг хэрэгжүүлэх нь Монголын ард түмнийг ажил төрөлтэй, сайн сайхан амьдрах нэг баталгаа болох юм. Гэхдээ нэг салбарын томоохон төслүүдээс хамаарсан эдийн засагтай байж болохгүй. Уул уурхайн төслүүдээс өгөөж хараад суух нь утгагүй. Анх бид Оюутолгой төслийг хэрэгжүүлэхэд мөнгө байхгүй гэж хэлээд сууж байхын оронд “юм үзсэн хүн шиг” дэлхийн хэмжээний тоглогч нартай “бүтээгдэхүүн хуваах гэрээ”-гээр хамтарч ажилланаа гээд сууж байх ёстой байлаа. Энэ бол мөнгөгүй хүний хамгийн сайн санал. Хэрэв бүтээгдэхүүн хуваах гэрээ хийж амжилттай хэрэгжүүлсэн бол монголчууд дэлхийн хэмжээний томоохон тоглогчидтой хэрхэн хамтарч ажиллах вэ гэдгээ олчихсон байх байсан. Гэвч улсдаа нэгдсэн бодлого байхгүйн улмаас томоохон компаниудад эд баялагаа ямарч ашиггүй бариад дуусах нь байна. Оюутолгойн гэрээг зөв хийсэн бол Таван толгой төслийг ашиглах оновчтой гэрээний загвар бэлэн байх байсан. Энэ мэт бидний ирээдүйд саад болж буй популист алхмуудыг халж байж энэ салбарын ирээдүй гэрэлтэх юм. ■



Хүчтэй. Хамтдаа.

Ард тэтгэврийн сан



ДУНДАЖ ЦАЛИН
МОНГОЛД

ЦАЛИНГИЙН
14 ХУВЬТАЙ ТЭНЦЭХ ХЭМЖЭЭГ
ТЭТГЭВРИЙН ДААТГАЛД
ТӨЛДӨГ

30-60 НАСНЫ ХООРОНД
АЖИЛЛАВАЛ


НИЙТ ХУРИМТЛАГДСАН
ТЭТГЭВЭР

САРД АВАХ ДУНДАЖ
ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ

МОНГОЛ ХҮНИЙ
ДУНДАЖ НАСЛАЛТ

ӨВЛҮҮЛЖ БОЛОХ
ХУРИМТЛАЛ

Улсын тэтгэврийн сан





Б.Нэмэхбаатар: “MCS” бол МОНГОЛЧУУДЫН ҮНДЭСНИЙ баялаг юм

Д.Бэхбаяр

“Заг” ХХК-ийн ерөнхий захирал Б.Нэмэхбаатартай ярилцлаа. Тэрбээр 1990-ээд оноос хойш бизнес эрхэлж, ялангуяа барилгын салбарт олон жилийн туршлага хуримтлуулсан бизнесмэн. Бид улс орны эдийн засаг, бизнесийн өнөөгийн байдлын талаар ярилцсан юм.

-Эдийн засгийн нөхцөл байдлаас болоод бизнес хийхэд улам хүнд болж байна. Бизнесийн салбарт олон жил зүтгэж, олон засгийн нүүр үзсэн бизнесмэнийн хувьд улс орны өнөөгийн байдлыг хэрхэн харж байна вэ?

-Ойрын хоёр жилд эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байхаар харагдаж байна. Харин Дэлхийн банк, АХБ-ны шинжээчдийн дүгнэлтээр эдийн засаг энэ жил 2-3 хувийн өсөлттэй гарна гэжээ. Би үүнийг их бодитой таамаг гэж үзэж байгаа. Улстөрчид өнгөрсөн хугацаанд эдийн засгийг дордоогүй байгаа мэтээр ярьж хэлж ирлээ. Манай улс өнөөдөр нэлээд гүнзгий хямралд орсон нь тодорхой боллоо. 2012 онд батлагдсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль хөрөнгө оруулалтыг үргээхэд их нөлөө үзүүлсэн. Мөн том төслүүдээ зогсоосон нь нэрмээс болсон. Дээрээс нь төр, засгийн удирдлага буруу бодлого баримталсан нь өнөөгийн нөхцөл байдалд хүргэсэн үндсэн шалтгаан гэж үзэж байна.

2008, 2009 оных бол хямрал

биш хүндрэл байж. Өнөөгийнхтэй харьцуулахад иргэд орлоготой байсан бол Оюутолгойн хоёр тэрбум орчим ам.доллар орж ирэхэд л эдийн засаг сэргээд ирсэн. Харамсалтай нь энэ сэргэлт ганц, хоёр жилээс хэтэрсэнгүй.

Манай улсын хувьд хоёр том зах зээлийн дунд оршдог баялагтай орон. Хүн ам нь залуу, чадавхитай гээд давуу талуудтай. Ойрын хугацаанд сэргэх боломж бүрэн бий. Түүнээс гадна монгол хүний сэтгэлийн хат, математик сэтгэмж, зохицох, хөрвөх чадвар гэсэн давуу талууд байна шүү дээ. Тухайлбал, хүн ам олонтой орны иргэд бол нэг бизнес нь дампуурахад сэтгэлээр их унадаг, амиа хорлох нь ч бий. Монгол хүмүүс бизнес нь нэлээд хүнд болчихлоо д байхад л маргааш нь ахиад бизнес хийх тухай ярьж явдаг. Энэ бол бидэнд байгаа том боломж. Монгол Улсад хийх ажил асар их байна. Хамгийн наад зах нь гэр хорооллыг барилгажуулах төслийг дурьдаж болно. Энэ төслийн хүрээнд багагүй ажил хийгээд байгаа ч Улаанбаатар хотын хүн амын 60 хувь нь гэр хороололд амьдарч байна гэхээр хийх ажил их л байна гэсэн үг.

-Бизнесмэнүүд өнөөдөр ямар байдалтай байна вэ?

-Ард иргэд нь орлогогүй болчихоор бүх л компанийн борлуулалт нь багасч, зээлээ төлж чадахгүй болж ирлээ. Зардлаа багасгаж, шаардлагагүй төслөө зогсоож байна. Ажлын байрыг

хадгалахад анхаарч, ашиг олохдоо гол биш бүтцээ хадгалж хямралыг давж гарах чиглэл баримталж байна. Бас зүгээр суухыг бодохгүй, гадна дотнын төслүүд, хөрөнгө оруулалт эрэлхийлсэн байдалтай ажиллаж байгаа.

-Танд энэ хямралаас гарах ямар гарц харагдаж байна. Төр хувийн хэвшлийнхний дэмжлэгтэйгээр эдийн засгийг сэргээх тухайд Та юу хэлэх вэ?

-Нэгдүгээрт, хувийн хэвшлийнхний идэвхтэй үйл ажиллагааг дэмжиж өгөх хэрэгтэй. Мэдээж ерөнхий утгаараа эдийн засгаа тэлж, том төслүүдээ хөдөлгөх ёстой. Оюутолгойн гүний уурхайн ажил явах байх. Харин Тавантолгойн төслийг зогсоосон нь маш буруу. Монголын нүүрс дэлхийн зах зээл дээр гарч, Австрали, Индонезтой өрсөлдөхөд хүнд. Гэтэл Японы том зах зээл рүү гарах боломжийг “Сумитомо”, төмөр замын өөрийн дэд бүтэцтэй “Шинхуа” нарын хамтрал хамгийн зөв гарц байсан гэж харж байгаа. “Энержи ресурс”-ын бий болгосон дэд бүтцийг хөрөнгө оруулалтдаа тооцоод явчихсан бол цаг хугацаа зарахгүйгээр ажиллах боломжтой байсан юм билээ. Одоо шинээр үйлдвэр барина гэвэл хэчнээн хугацаа орох бол.

“М Си Эс” бол монголчуудын бас нэг баялаг юм. Дэлхийн стандартад дөхөж очсон Монголын бизнесийн жишиг болсон компани гэж бид үздэг. Гадаад зах зээл дээр “ММС”-

ийн хувьцааны үнэ унаж байгааг бүгд харж байна. Энэ хүнд үед нь олон улсын түвшинд хүрсэн менежменттэй үндэсний компани төр, засаг нь дэмжээд явах ёстой. Америк, Германд машин үйлдвэрлэлийн салбартаа төр, засаг нь асар их хөрөнгө оруулж, үндэсний компаниудаа бодлогоор дэмжиж өгдөг. Гэтэл манай төр хэдэн хүн баяжих нь гэж харж, зах зээлийнхээ эсрэг шийдвэр гаргах юм. Үүнд бизнесийнхэн маш их эмзэглэсэн. Гуравхан гэр бүл л баяжих гээд байна гэх. Иргэн нь л юм чинь хэдэн хүн байх нь ямар хамаа байна. Тэд чинь олон мянган ажлын байр бий болгож байгаа шүү дээ. Үндэсний том группүүдээ дэмжихийн оронд нэгнийгээ бүр мөсөн нухах гээд тэмцэлдээд байх юм.

Би "М Си Эс" ХХК-тай ямар ч хамааралгүй хүн. Гэхдээ тус компанийн бүтээж байгуулсан гавьяаг нь хүндэтгэдэг. Тухайлбал хүний нөөцийн бүхэл бүтэн "арми" нийгэмд бэлдэж гаргасан. "М Си Эс"-д ажиллаж бэлтгэгдсэн боловсон хүчнүүд хаа сайгүй л ажиллаж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамгийн чухал зүйл нь хувийн хэвшлээ дэмжих байдаг.

Хоёрдугаарт, эдийн засгийн зөв бүтэцтэй байх тухай их ярьдаг. Бёбайдаг. Ялангуяа Өмнөд Солонгос. Байгалийн баялаг байхгүй учраас боловсролын салбараа маш сайн дэмжиж, хүнээ хөгжүүлж чадсан улс. Боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлж, эдийн засгийг уул уурхайн хэт хамаарлаас гаргаж, экспортын чиглэлийг тууштай баримтлах хэрэгтэй байна.

Монгол-Японы эдийн засгийн түншлэлийн гэрээ нь экспортыг дэмжсэн том алхам юм. Энэ бол Монголын төр хийх ёстой ажлаа нэр төртэй гүйцэтгэсэн хэрэг. Бизнесмэнүүд үүнийг ёстой чулуу болгох хэрэгтэй. Бид ч энэ чиглэлд ажиллаж байна.

Гуравдугаарт, барилгын салбарын хувьд нийлүүлэлт нь эрэлтээ давчихлаа. Зах зээлд 30 мянган айлын орон сууц бэлэн барьчихсан байна. Тэгэхээр төрөөс банк санхүүгийн байгууллагуудтай хамтраад үл хөдлөх хөрөнгийг гадаад буюу хоёрдогч зах зээл дээр гаргах ажлыг Моргежийн зээлийн багцыг зохион байгуулах шаардлагатай. Ялангуяа Зүүн Өмнөд Ази, Хонгконг, Хятадад манай үл хөдлөх

хөрөнгийн зах зээлийг сонирхож байна.

Би банкны системд их шүүмжлэлтэй ханддаг хүн. Даатгал, санхүүгийн зах зээл, Хөрөнгийн бирж, бусад салбарыг дорвитой хөгжүүлмээр байна. Санхүүгийн зах зээлийн 97 хувийг банк эзэлдэг. Одоо хэдэн банк нь мөнгө хүүлдэг ажил л хийж байна. Банк дампуурвал хохирлыг төр барагдуулдаг, Засгийн газрын бондыг засгийн мөнгөөр банкууд л авдаг. Зээлийн хүү нь өндөр. Гаднын банкыг оруулж ирэх гэхээр үндэсний аюулгүй байдал гэж ярьдаг. Үнэн хэрэгтээ тодорхой хязгаарыг нь хуулиар зохицуулаад гадаадын банкуудыг оруулж ирж ажиллуулах нь зөв гэж хардаг.

Өөр нэг зүйл нь хууль эрх зүйн орчин. Сүүлдээ гадаадынхан битгий хэл дотоодынхон ч учраа олохоо болилоо. Хэдэн толгой ажиллалаад байгаа юм, тэдгээр нь бүгд нэгдмэл биш, өөр өөр зүг харсан толгойнууд байх шиг. Засгийн газраас өнөөдөр Тавантолгойг хөдөлгөлөө гэж мэдэгдэхэд маргааш нь УИХ явуулахгүй гээд л зогсоочихдог. Саяхан барилгын нэгэнт хийгдсэн 260 тэрбумын ажлыг векселээр санхүүжүүлэх шийдвэр гарсан. Гэтэл шалгалт оруулна гээд сарын хугацаа өнгөрлөө. Ийм тодорхойгүй байдлыг цэгцлэх шаардлагатай. Нэг шийдвэр гаргаад маргааш нь өөрчлөөд, эсвэл удааж хугацаа авдаг, эсвэл төр, засаг нь унаж, зарим гишүүнээ солих зэрэг тогтворгүй байдалд гадны хөрөнгө оруулалт орж ирэх үү. Нөгөө талаас намууд төрийн албыг маш их бужигнуулж байна. Ийм нөхцөлд төртэй түншлэх асуудал ярихад бэрх шүү дээ.

-Та Өршөөлийн хуулийг хэрхэн үзэж байна. Бизнесмэнүүдийн зарим нь дэмжиж, нөгөө хэсэг нь буруу гэх юм.

-Зарчмын хувьд буруу. Өршөөлийн хуулиудын хоорондын хугацаа ойрхон байна. Хэдэн жил болоод л өршөөдөг, түүнийг нь тодорхой хүмүүс түрүүлээд мэдэж л байдаг, тэр хуульд хамрагдахаар гээд эртнээс бэлтгэдэг байдал харагдаж байна. Гэтэл улс төрөөс хол бизнесмэнүүд нь татвараа шударгаар төлөөд л явдаг. Эдийн засгийг ил тод болгоно, далд эдийн засгийг зогсооно гэж ярьж байгаа ч далд эдийн засагт хэчнээн хэмжээний мөнгө эргэлддэгийг хэн ч хэлж мэддэггүй. Зүгээр л таамгаар,

манан дунд бужигнуулж, өөрсдөдөө ашигтайгаар хуулийг заалтыг хийдэг.

Миний бодлоор далд эдийн засгийг ил болгохын тулд бүх хүний хөрөнгө орлогыг өмнө нь тийм байсан энэ жил тэд болж өссөн, тийм эх үүсвэрээс төчнөөн хэмжээний төгрөг орж ирсэн гэх мэтээр яг тодорхой болгох хэрэгтэй. Ялангуяа төрийн өндөр албан тушаалтан, түүний ах дүү, ойр дотнын хүмүүсийнхийг. Манайд "Би компани гурван жилийн өмнө эхнэртээ шилжүүлсэн" гэсэн тайлбар хэлж, хөрөнгө орлогын мэдүүлэгтээ тэр компанийн жаахан хувьцаа, хэдэн адуу, нэг машин гэх мэтээр бичээд сууж байх юм. Энэ бол дэндүү утгагүй зүйл. Энэ бүхнийг нэг мөр цэгцэлж байж "Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль"-ийг батлах ёстой байсан.

Манай онцлог бол цөөхөн хүн амтай, нэг сургуульд цуг сурч байсан, нэг нутгийнх, ийм тийм клубт хамрагддаг гэх мэтээр бүгд бид биенээ мэддэг. Энэ онцлогт ямар юмыг танил тал, ямар юмыг ашиг сонирхлын зөрчил, хэн нь хэнийгээ ажилд авч болохыг тусгай институтц гаргаж тодорхой хугацаанд судалж байж хууль гаргах хэрэгтэй байсан. Гадаадын оронд эхнэр нь албаны машин авч хил давахад л шууд нөхөр нь огцорч байна. Төрийн албан хаагч ямар нэг асуудалд холбогдохгүй байх ёстой. Манайд шүүхээр нотлогдоогүй бол хамаагүй гээд л суугаад байдаг. Ийм шударга бус асуудлуудыг засах ёстой. Хуульчид, эрдэмтэн судлаачид, хэвлэлийнхэн хамтраад хийх хэрэгтэй байна.

-Барилгын салбарын хөгжлийг хэрхэн хардаг вэ?

-Банкуудын хамгийн сайн бүтээгдэхүүн моргэйж байдаг. 90 гаруй хувийн төлөлттэй, чанаргүй, хугацаа хэтэрсэн зээл бараг байхгүй явж байна. Иргэдийн хувьд гэр орон нь хамгийн чухал учир зээлээ яаж ийгээд л төлдөг. Төр, засгаас эх үүсвэрийг шийдэж өгөөд байвал энэ төсөл үргэлжлээд байх боломжтой.

Ганцхан салбарын хувьд ингэж, тэгвэл хямралаас гарна гэж ярих их учир дутагдалтай. Макроэдийн засгаа сайжруулаад, том төслүүдээ явуулж, хөрөнгө оруулалт татаж, иргэд нь орлоготой болж байж л бүх салбар урагшаа явна. Монголд 4000 барилгын

компани бүртгэлтэйгээс 10 хувь нь ажилладаг, мөн хуурамч компаниуд, тендер авдаг зэрэг жижиг сажиг асуудал бий.

Үүнийг бодлого барьж байгаа яам мэргэжлийн боловсон хүчин ажиллуулснаар шийдчих асуудал. Барилга бол эдийн засаг нь тогтвортой сайн байвал ажиллаж л байдаг салбар. Боловсон хүчин ч сайжирсан, орчин үеийн техник технологи нэвтэрсэн, ажил байвал гадаадад ч барилга барих чадамжтай болсон, Монголын барилгын салбарынхан. Эхнээсээ гадаадад барилга барих боломжийг судалж байна. Энэ бол хөгжил. Зөв бодлогоор дэмжих л чухал юм.

-Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг 10 хувь болгож бууруулсан. Энэ хэр зөв зүйтэй шийдвэр вэ?

-Зөв. Иргэд өнөөдөр орлого муутай байна. 30 хувь бүү хэл 10 хувиа ч өгч чадахгүй байна шүү дээ. Урьдчилгаа мөнгө нь багасч байгаа болохоос төлөх зээл нь багасаагүй. Моргейжийн зээлээ санхүүжүүлэх эх үүсвэр нь байгаа бол орон сууцнууд нь борлогдож барилгын салбарт түгжигдсэн мөнгө эргэлтэд ороод ирэхээр эдийн засаг сэргээд ирнэ.

-Монгол Улс хөрөнгө оруулалтгүйгээр хөгжих боломж бий юу?

-Ямар ч боломж байхгүй. Энэ том төслүүдийг гадаадын хөрөнгө оруулалтгүйгээр явуулах, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлж чадахгүй. Манайх шиг дэд бүтэц сайн хөгжөөгүй газар тааламжтай тогтвортой орчин маш чухал.

-Барилгын салбарт гадаадын хөрөнгө оруулалт байдаг уу?

-Байгаа. Ер нь ойролцоогоор 40 хувиас багагүй байх. Ялангуяа Хятадын хөрөнгө оруулалт их бий.

-Танай компанийн хувьд бизнес чинь ямар байна вэ. Гэр хорооллыг орон сууцжуулах төсөл дээр ажиллаж байгаа гэл үү?

-Гэр хорооллыг орон сууцжуулах төслөө түр зогсоогоод байгаа. Уг нь манайх чинь их том газарт орон сууц барих зөвшөөрөлтэй. Бүх зураг төсвөө батлаад, айл өрхүүдтэйгээ гэрээгээ байгуулаад, шугам сүлжээний ажлаа хийчихээд байтал эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчид маань түдгэлзсэн учир



Фотог: Б.Бямба-Очир

хүлээлтийн байдалтай орчихоод байна. Одоо орон сууц барихад нэгдүгээрт, хөрөнгө хэрэгтэй, хоёрдугаарт, худалдан авагч хэрэгтэй, гуравдугаарт, борлогдоогүй орон сууц зах зээлд олон байна. Тиймээс төслөө түр зогсоочихсон. Манай компани уул уурхай, боловсрол, барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байна. Ирэх жилүүдийг хэмнэлтийн байдалд өнгөрөөх төлөвлөгөө баталсан. Гэхдээ төсөл, судалгааны ажлаа зогсоохгүй, мөн ажилтнуудаа аль болох халахгүйг хичээн ажиллаж байна.

Монголын улс төр үнэндээ бизнес, эдийн засагт маш их сөргөөр нөлөөлж байгааг бүгд мэдсээр байна. Энэ бүгдийг бас цэглэх шаардлагатай нь харагдаж байгаа. Таны хувьд ямар бодолтой байна вэ?

-Одоо энэ улстөрчдийн нөөц нь шавхагдсан шиг байгаа юм. Хэрвээ хүсэл байвал намуудын тухай хуульд өөрчлөлт оруулж, намуудын санхүүжилтыг ил тод, намыг гишүүнчлэлгүй болгох

хэрэгтэй. Тэдний хэлж байгаагаар Монголд нам төлөвшөөгүй гэдэг. Намууд гишүүнчлэлгүй болж, иргэдийг сонголтоо чөлөөтэй хийх эрх чөлөөг олгох ёстой. Үгүй бол аймаг, сумд, багт гээд нам, намаараа хуваагдчихсан. Тиймээс намуудын тухай хууль, намын санхүүжилтийн тухай хуульд өөрчлөлт хийх хэрэгтэй. Ялангуяа намуудын санхүүжилтийг ил тод болгосноор асуудал нэлээд шийдэгдэх болов уу.

Ер нь байдлыг харахаар одоо байгаа улстөрчдийн бүрэлдэхүүний 80 хувь нь шинэчлэгдэх шаардлагатай. Түүнээс гадна манайд байгаа нэг юм нь ахмадаа, уламжлалаа үгүйсгэдэг. Санаагаар болдог бол УИХ-д олон жил болсон тууштай, нуруутай улстөрчид нь үлдээд, шинэ залуу нь тэд, эрдэмтэд тэд, эдийн засагчид, хуульчид тэд гээд тоог нь тэнцүүлмээр. Төр бизнест бага оролцоотой байвал сайн гээд байдаг боловч, манайд бүх бизнесмэнүүд нь төр засагт ороод суучихсан болохоор л төрийн оролцоо ихсээд л байна шүү дээ. ■

ТАТВАР

Үйлдвэржилтийн анхны алхам



10 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний гаалийн албан татварын хэмжээг 6.5-20 хүртэл хувь байхаар нэмж тогтоолоо.

Г.Орхон

Засгийн газар үйлдвэржилтийг дэмжих дорвитой алхам хийсэнгүй гэдэг үе наадмын удаах сартай хамт “моод”-ноос гарлаа. Өнөөх дорвитой алхам нь Засгийн газрын ээлжит хуралдаанаар буюу наймдугаар сарын 17-нд импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай тогтоолыг баталсан явдал. Ийнхүү дотоодод үйлдвэрлэж буй бараа, бүтээгдэхүүнтэй ижил төрлийн импортын зарим барааны гаалийн албан татварыг нэмэхээр болов.

Хүнсний болон барилгын материалын тодруулбал, өндөг, боловсруулсан махан бүтээгдэхүүн, зайрмаг, цемент, хаалга, цонх зэрэг 10 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний гаалийн албан татварын хэмжээг өмнө нь 5-10 хувь байсныг 6.5-20 хүртэл хувь байхаар нэмж тогтоолоо. Ингэснээр дотоодын үйлдвэрийн өрсөлдөх чадварыг сайжруулж, ажлын байр нэмэгдэнэ. Аж үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Билгүүн “Энэ нь дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдээ хамгаалж буй учир эдийн засагт өгөөжтэй. Тэдэнд зах зээлээ тэлэх маш том боломж гарч ирж байна. Үйлдвэрлэгчид зах зээлээ тэлж, үндэсний үйлдвэрүүд маань бэхжээд ирвэл цаашдаа жижиг, дунд үйлдвэрүүд экспортод гарах үе шат руугаа орно. Үйлдвэржилтийн бодлого гурван үе шаттай явж байгаа. Эхлээд өөрсдийгөө хамгаалъя, экспортод нь дэмжлэг үзүүлбэ, дараа нь шинэ технологийг нэвтрүүлж, оюуны бүтээмж шингээсэн үйлдвэрлэлийг дэмжих юм” гэв.

Засгийн газрын тогтоол гарсан ч салбарын яаманд бараа, бүтээгдэхүүний нэр төрөл, татварын хувь хэмжээг эцэслэж ирүүлээгүй байгаа аж.

Уг алхамыг олон хүн нааштай хүлээж авч байгаа ч иргэдийн зарим нь эргээд “Үндэсний үйлдвэрлэлийнхэн нь бараа, бүтээгдэхүүнийхээ үнээ нэмэх вий” гэж сэм хардаж сууна. “Гэхдээ дотоодын үйлдвэрээ дэмжих бодлого нь зөв ч, импортыг хааж болохгүй. Импортын бараа нь үнийг

тодорхой түвшинд барьж байгаа” хэмээн импортлогчдын зарим нь ундууцаж байх. Иргэн Ц.Мөнх “Би цементийн наймаа хийдэг. Өнөөдөр Эрээнд нэг тонн цемент 85 мянган төгрөг байгаа бол Хөтөлд 155 мянган төгрөг байна. Үүний учрыг би ердөө олж чадахгүй нь” гэж байна. Харин “Говь Хангай Мебел” ХХК-ийн Буйдангийн үйлдвэрийн дарга Д.Батчулуун “Ингэж байж үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж монголчууд ажилтай болж амьдрал дээшилнэ. Манай компани сард 2000 метр, иж бүрдлээрээ 800-900 ширхэг буйдан үйлдвэрлэдэг. Бид анх импортын үнээс хямд, чанартай буйдан үйлдвэрлэх зорилготой гарч ирсэн. Үүнийхээ тусгаар хямралыг давж байна” гэсэн юм.

Цаашид Монголын үйлдвэрүүд чанар дээрээ анхаарахыг иргэд сануулж байна. Импортоор орж ирж буй зарим бараа, бүтээгдэхүүний үнэ өндөр байдаг ч дотоодод үйлдвэрлэснээс чанарын хувьд илүү гэж үзэх нь бий. Ямар ч гэсэн үндэсний үйлдвэрлэгчдэд төрөөс чамгүй дэм өглөө. Харин одоо үйлдвэрлэгчид дотоодынхоо хэрэгцээг чанартай, хямд бараа, бүтээгдэхүүнээр хангахыг төлөө чармайх л үлдлээ. Дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэгч орнууд тухайлбал, Тайванийн улсын хөгжлийн гарц жижиг, дунд үйлдвэрлэл байсныг энэ оны дөрөвдүгээр сард болсон Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үндэсний чуулганы үеэр онцолж байсныг энд тэмдэглэе.

УИХ-ын тогтоолоор импортын барааны гаалийн татварын хувь, хэмжээг тухайн салбарын бүтээгдэхүүний онцлогийг харгалзан тогтоох эрхийг Засгийн газарт олгосон байна. Ийнхүү Засгийн газар 300 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний гаалийн татварыг, өсгөх бууруулах эрхтэй болов. Монгол Улс дэлхийн худалдааны байгууллагын гишүүн тул бараа, бүтээгдэхүүний импортын татварыг 15-20 хувь хүртэл нэмэх боломжтой аж.

Дотоодын үйлдвэрлэгчид хийж, бүтээж байгаа ч бараа, бүтээгдэхүүний борлуулалт муу буй тэд олонтаа учирладаг. Засгийн газар энэ удаа дорвитой хөдөлж зах зээлд импортын зарим нэр төрлийн барааны гаалийн татварын хувь хэмжээг нэмэхийн зэрэгцээ төсвийн мөнгөөр дотоодоос худалдаж авах барааны жагсаалтыг гаргалаа. Энэ нь дотоодод үйлдвэрлэсэн нэр бүхий барааг заавал худалдаж авах шийдвэр гаргасан гэсэн үг. Уг жагсаалтад бүх төрлийн хэвлэмэл, оёмол, эсгий бүтээгдэхүүн тэргүүтэй 80 орчим бараа, бүтээгдэхүүнийг оруулжээ. Мөн ноос, ноолууран болон мод, модон бүтээгдэхүүн, савхин хувцас, зам, барилгын материал, төмөр хийц, сав баглаа боодлыг багтаасан байна. Тус жагсаалтыг төрийн болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлэх гэнэ. Монголд ийм замаар дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, худалдан авалт нь огцом өсч байсан удаа бий. Засгийн газрын 2011 оны 103 дугаар тогтоолоор ийм төрлийн жагсаалтыг батлан хэрэгжүүлснээр дотоодын үйлдвэрийн барааг худалдан авах хэмжээ нэг жилийн дотор таван тэрбумаас 50 тэрбум болж 10 дахин өсчээ.

Төрийн бодлого үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжихэд чиглэж буй. Харин одоо үйлдвэрлэгчид “Made in Mongolia” шошготой өндөг, цемент, хаалга, цонх юуныхыг үйлдвэрлээд байж дээ. Хамгийн гол нь хаа хаанаа уян хатан байх учиртай. ■

МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ЗӨВЛӨЛ

Монголын Бизнесийн Зөвлөл нь Монгол Улс дахь худалдаа, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах үндсэн зорилготойгоор анх 2007 оны намар байгуулагдсан. МБЗ нь бизнесийн орчинтой холбоотой асуудлуудаар дотоод болон гадаадын хөрөнгө оруулагч гишүүдийнхээ дуу хоолой, төлөөлөл болон ажилладаг.

CAT S-O-SSM 5 YEARS

1971 ОН

CAT® машины ашигласан тосыг шинжлэн, тослогддог эд ангиудын элэгдлийг оношлох S-O-SSM үйлчилгээг дэлхий дахинд танилцуулав.

Cat® S-O-SSM Services

1972 ОН

“Вагнер Тоног Төхөөрөмж” компани S-O-SSM үйлчилгээг харилцагчиддаа санал болгож эхэлсэн **анхны диллерүүдийн нэг** боллоо.



2010 ОН



“Вагнер Ази Тоног Төхөөрөмж” ХХК нь S-O-SSM тосны лабораторийн үйлчилгээг **Монгол улсад нэвтрүүлэв.**

2012 ОН

“Вагнер Ази Тоног Төхөөрөмж” ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах салбартаа **OSA бичил лабораторийг** байгуулав.



2013 ОН

S-O-SSM хөргөлтийн шингэний шинжилгээг Монгол Улсад нэвтрүүлэв.



2015 ОН

100 гаруй харилцагч байгууллагаас ирсэн 65 000 гаруй тосны дээжинд шинжилгээний ажил хийж гүйцэтгэв CAT®-ын хийсэн судалгаагаар харилцагч S-O-SSM үйлчилгээнд зарцуулсан **\$1 дутамд \$10 хэмнэдэг** гэсэн дэлхийн дундаж байдаг бол Монгол Улсад 2014 оны 12 сард нэг сарын хугацаатай зарлагдсан аяны хүрээнд хийсэн судалгаагаар, харилцагчид маань **26.4 сая төгрөгийг S-O-SSM үйлчилгээнд зарцуулж, 1 тэрбум 528 сая төгрөгийн хэмнэлтийг** хийсэн байна.

\$1 >>> \$58

зарцуулалт

хэмнэлт

S-O-SSM үйлчилгээг ашиглан Монгол Улсад ажиллаж байгаа CAT®-ын топ 15 моделийн машины зөвхөн хөдөлгүүрийн тосны ашиглалтын хугацааг 100 цаг уртасгахад 3 жил буюу 20 000 мотоцигийн хугацаанд **ТОСНЫ ХАЯГДЛЫГ 1065TH-ООР БУУРУУЛАХ** боломжтой.

2015 ОН

ТРИМБЛИЙН LOAD-RITE буюу Жин хэмжүүрийн системийг албан ёсоор нийлүүлэх эрхтэй боллоо. Уг систем нь 1979 оноос хойш жин хэмжүүрийн болон дэлгэцийн хяналтын технологиор дэлхийд тэргүүлж 50 гаруй оронд танигдаад байгаа систем юм.

TERRAIN™ системийг Оюу-Толгойн уурхайн Liebherr R9400 - Гидравлик экскаватор, Sandvik DR580 – Өрөмийн машинууд дээр тус тус амжилттай нэмж суурилууллаа.

2014 он

TRIMBLE-ийн SPS - Байршил тогтоох замын хэмжилтийн GPS-ийг Монгол хэл дээр ашиглах боломжтой боллоо.



2014 он

Монгол Улсад Авто Замын салбар үүсч хөгжсөний 85 жилийн ойн баярыг тохиолдуулан Авто Замчдын ур чадварын тэмцээн зохион байгуулж СХД -н Зүүн Салаанд 500м замын суурь ажлыг тавьж өглөө.



2013 он

CAT® MINESTAR™ Уул уурхайн автоматжуулалтын цогц шийдлийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох **TERRAIN™** системийг Монгол Улсдаа төдийгүй Хамтын нөхөрлөлийн холбооны улсуудын бүсийн хэмжээнд анх удаа нэвтрүүлж Оюутолгой уурхайн 10 машинд (6060 - Цахилгаан шовель 2ш, 7495 Цахилгаан экскаватор 2ш, Komatsu WA1200-3 - Дугуйт ачигч 2ш, Atlas Copco PV351 - Өрмийн машин 4ш) амжилттай суурилуулж бүрэн ашиглалтад оруулж хүлээлгэн өглөө.

CAT® MINESTAR™ SYSTEM



2013 он

Улаанбаатар хотын Олон Улсын Шинэ онгоцны буудлын барилгын ажилд **TRIMBLE-ийн** Машин Удирдлагын систем болон **SPS**-Байршил тогтоох замын хэмжилтийн системийг ашигласнаар бага зардлаар өндөр бүтээмжтэй ажиллаж байна.



2012 он

Дэлхийд тэргүүлэгч АНУ-ын **TRIMBLE** компанийн Барилга Замын салбарын **ТЕХНОЛОГИЙГ** нийлүүлдэг олон улсын **САЙТЕК** сүлжээний Монгол дахь албан ёсны дилер боллоо.

Оюутолгой төслийн “Хан Бумбат” олон улсын стандартын нисэх онгоцны буудлын онгоц хөөрөх-буух зурвасын барилгын ажилд **TRIMBLE-ийн** Машин Удирдлагын систем анх ашиглагдлаа.



2012 он

CAT® PAVING DAY- Замын өдөрлөг зохион байгуулж орчин үеийн Машин Удирдлагын Системийг ашиглан 50м зам барьж үзүүлэн, замын технологийн талаар олон улсын семинар, сургалтыг Монгол Улсад анх удаа амжилттай зохион байгууллаа.





Компанийн засаглалын бодит үлгэр жишээ

Тэртээ 1924 он байгуулагдсан “АПУ” компани 1992 онд Монголын хөрөнгийн биржид бүртгүүлжээ. Компанийн гаргасан 74,287,700 ширхэг энгийн хувьцааг 3.545 /2015.3.31-ний байдлаар/хувьцаа эзэмшигчид эзэмшдэг байна. Тус компани нь МХБ-д бүртгэлтэй шилдэг компаниудын нэг бөгөөд ялангуяа компанийн засаглалыг бодитоор хэрэгжүүлэгч үлгэр жигээ хамт олон юм.

АПУ компани 1924 онд 14 ажилтантайгаар байгуулагдсан цагаас хойш архи, пиво, ус ундаа, сүү, жүүсний шилдэг брэндүүдийн цуглуулгатай үндэсний топ үйлдвэр болтлоо хөгжлийн гайхамшигтай замыг туулсан юм.

Цаашид дээд зэргийн брэндүүдийн багц,чанарын уламжлал ба шинэчлэлд тулгуурлан олон улсад хөгжихөөр төлөвлөжээ.

Тэдний амжилт дараах хүчин зүйлүүдэд тулгуурласаар ирсэн юм.

АПУ компани болон түүний түншүүд 1000 гаруй мэргэжилтэнтэй бөгөөд үндэсний хамгийн том түгээлтийн сүлжээний тусламжтайгаар бүтээгдэхүүнээ 6000 гаруй худалдааны байгууллагуудаар дамжуулан борлуулж байна.

Компанийн засаглал гэж “Хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг болон тэдэнтэй адил тэгш харьцах зарчим, мэдээллийн ил тод байдал, компанийн удирдлагын үүрэг хариуцлагын тогтолцоо”-г хэлдэг. Мөн олон улсын хүрээнд дараах компанийн засаглалын үндсэн зарчмуудыг чухалчлан авч үздэг. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал
2. Хувьцаа эзэмшигчдийн адил тэгш байдал
3. Компанийн засаглалд оролцогч талуудын хүлээх үүрэг
4. Нээлттэй ба ил тод байдал
5. ТУЗ-ын хүлээх үүрэг хариуцлага зэрэг ордог. Харин “АПУ” ХК нь эдгээр үндсэн зарчмуудыг бодитоор амжилттай хэрэгжүүлж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурал: Тус компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг /ХЭХ/ жил бүрийн дөрөвдүгээр сард тогтмол хуралдуулж хэвшсэн. Мөн компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан, тэдний эрхийг адил тэнцүү хангаж сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэхийн тулд ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын албан тушаалыг

тусгайлан бүтээжээ батлан ажиллуулдаг. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь ээлжит болон ээлжит бус хурлыг “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу” олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарладаг. Хувьцаа эзэмшигчдийн саналыг хурлаас өмнө шуудан, и-мэйлээр авах тухай зарладаг ба хурал дээр санал хураалтыг хуулинд заасны дагуу авдаг.

Ногдол ашиг тараасан байдал: “АПУ” компани нь 1992 оноос хойш өнөөдрийг хүртэл 18 удаа хурал зарлан хуралдуулж, нийт 141.382.122.009.00 төгрөгийн ногдол ашгийг МХБ, ҮЦТТХТөв болон Үнэт цаасны компаниар дамжуулан түгээсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ : Тус компани нь ТУЗ-ийн гишүүдийг ХЭХ-аар сонгосон ба нийт есөн гишүүний гурав нь хараат бус гишүүд байна. ТУЗ-ийн дэргэд Аудитын хороо, Цалин урамшууллын хороо болон нэр дэвшүүлэх хороог байгуулсан. Мөн ажлын албатай ба бүрэлдэхүүнд ТУЗ-ын Нарийн бичгийн дарга, үнэт цаас хариуцсан мэргэжилтэн, хуулийн зөвлөх, нягтлан бодогч багтдаг аж.

Нээлттэй ба ил тод байдал: Олон улсын стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, баримт бичгийг мөрддөг. Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж ажилладаг. Хөндлөнгийн аудитын компаниар KPMG ХХК 2010 оноос хойш хамтран ажиллаж байгаа. Компанийн үйл ажиллагаа, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, хурлын шийдвэр зэрэг олон нийтэд түгээх мэдээллийг Хөрөнгийн бирж болон компанийн өөрийн цахим хуудсаар дамжуулан хүргэдэг. СЗХ-ны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол мэдээлэх тухай” 505-р журмын дагуу боломжит мэдээллийг нийтэд түгээж хэвшсэн.

Компанийн засаглалын хэрэгжилтийн үнэлгээ: Компанийн засаглалын хэрэгжилтийг тодорхойлох гол механизм нь засаглалын “үнэлгээ” бөгөөд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын засаглалыг үнэлэх, сайжруулах, олон нийтэд мэдээлэх үүднээс ТОП-20 индексийн сагсыг бүрдүүлэгч хувьцаат компаниудтай хамтын ажиллагааны тунхаг бичигт гарын үсэг зурсан. Энэ хүрээнд хагас жил тутамд аж ахуйн нэгжүүд өөрөө өөрийгөө үнэлэх үнэлгээний ажлыг хийж эхлээд байна. Үнэлгээний талаарх мэдээллийг МХБ-ийн албан ёсны цахим хуудаснаас www.mse.mn үзэх боломжтой. ■

БОНД

Эрчээ авсан Эрчим бонд

А.Бүрэнжаргал



“Эрчим бонд”-ын анхдагч зах зээлийн арилжааны нээлт

Улсын эдийн засаг сайнгүй байгаа энэ саруудад төрийн санхүүжилтээр урагшлах төсөл хөтөлбөр, дэд бүтцийн ажлууд ар араасаа зогссоор байна. Эрвийх дэрвийхээрээ гэдэг шиг дор бүрнээ ажлаа урагшлуулахын төлөө ажиллаж байгаа нь үнэн. Гэсэн ч салбар бүрт бэлэн мөнгөний гүйлгээ муудаж тэр дундаа томоохон дэд бүтцийн төслүүд хугацаагаа сунган хөдлөхгүй зогсох энүүхэнд болчихоод байна. Эдийн засгийн өсөлт эрчээ алдсан энэ хугацаанд харин хөрөнгийн бирж эрчийг авч олон төрлийн шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлж сайн мэдээг дуулгасаар буй. Яг л энэ өдрүүдэд хөрөнгийн зах зээлээс хүчээ сэлбэсэн “Эрчим Инженеринг” ХХК манай улсад шинэ төрлийн бүтээгдэхүүн болох даатгагдсан бондын үйлчилгээг санхүүжилтийн нэг хэрэгсэл болгон амжилттай хэрэгжүүлж чадлаа.

Тус компани нь 1999 оноос эрчим хүчний үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх чиглэлээр байгуулагдсан. Мөн үеэс өнөөдрийг хүртэл эрчим хүч, уул уурхай, нийтийн аж ахуй, барилгын салбаруудад өөрийн үйл ажиллагаагаа явуулсаар иржээ. Харин салбаруудын хөрөнгө оруулалт зогсонги байгаа энэ хугацаанд “Хүчит шонхор” зах орчмоор эрчим хүчний өргөтгөл хийж буй ажлаа урагшлуулахаар хөрөнгийн зах зээлийн даатгагдсан бондын үйлчилгээг анх удаа нэвтрүүлсэн байна. “Эрчим Бонд” жилийн 18.5 хувийн хүүтэй бөгөөд (сарын хүү 1.54 хувь) зургаан сарын хугацаатай бондыг олон нийтэд санал болгосон.

Наймдугаар сарын 12-ны өдрөөс тус сарын 21-ний хооронд “Эрчим бонд”-ыг хямдруулсан үнэтэйгээр буюу нэгж тус бүрийг 9155 төгрөгөөр худалдан хугацааны эцэст үндсэн үнээрээ тооцож хүүгээ хүртэх боломжтой аж. Нийт 50 мянган ширхэг буюу 500 сая төгрөгийн бонд арилжаалагдсан. Харин 236.194 ширхэг буюу 2.4 тэрбум төгрөгийн бонд худалдан авах захиалга арилжааны системд бүртгэгдсэн бөгөөд энэ нь нийлүүлэлтээсээ 4.7 дахин их байсныг Хөрөнгийн биржийн Маркетинг, олон нийттэй харилцах албаны захирал Ж.Мягмарсүрэн хэлсэн.

Түүнчлэн Голомт банк андеррайтерийн үйл ажиллагааныхаа хүрээнд Монгол Улсад анх удаа 100 хувь даатгагдсан “Эрчим бонд”-ыг хөрөнгийн зах зээл дээр нэвтрүүлсэн. Хөгжлийн түүхэнд цоо шинэ хуудсыг нээж байгаа энэхүү бондыг “Соёмбо Даатгал” ХХК даатгасан аж. Бондын үндсэн андеррайтераар Голомт банк, туслах андеррайтераар “Голомт Секюритиз” ҮЦК ажилласан бөгөөд эцсийн үр дүнг хөрөнгө оруулагчдаа харуулах л үлдээд байна.

Тус компаниас гаргаж буй бондын хамгийн анхны худалдан авагч нь байгууллагын ажилчид. “Эрчим Инженеринг” ХХК нь 60 ажилтантай бөгөөд боломж бололцоогоороо компанийнхаа хөрөнгө оруулагчид болсон тухай “Эрчим Инженеринг” ХХК-ны Захиргааны менежер Б.Ундрэм бахархан ярьсан. Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хэрэгжсэн тул үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг

эхлүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос шийдвэрлэсэн байна.

Энэ нь хөрөнгө оруулагчид өөрийн эзэмшлийн өрийн хэрэгслээ худалдах замаар эргэлтэд оруулах, анхдагч зах зээлээс худалдан авч чадаагүй хөрөнгө оруулагчдад боломж нээгдэх юм. Хорооны зүгээс хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэхэд онцгой анхаарч байгаа бөгөөд аж ахуйн нэгжүүд дээрх төрлийн болон бусад санхүүгийн хэрэгсэл гаргах замаар хөрөнгийн эх үүсвэр татах бүрэн боломжтойг илтгэсэн юм. Бондын эргэн төлөлтийг “Эрчим Инженеринг” ХХК нь бондын хугацааны туршид орж ирэх төслийн санхүүжилтээс хийх аж. Бондын даатгал нь санхүүгийн даатгалын нэгэн шинэ төрөл бүтээгдэхүүн төдийгүй хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг даатгалын компани 100 хувь батлан дааж буй учир ямар ч эрсдэлгүй хүү өндөр гэдгээр нь олон нийт идэвхтэй байгааг салбарынхан хэлж байсан юм.

Татан төвлөрүүлсэн хөрөнгөөрөө тус компани тендерийн ажлын гүйцэтгэлд шаардагдах эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлж буй. Энэ мэтчилэн 5-10 тэрбумын компанийн бонд энэ ондоо багтан хөрөнгийн зах зээлд шинээр нэвтрүүлэх боломжтой гэж удирдлагуудын зүгээс тооцоолж байна. Салбар бүрт санхүүгийн байдал сайнгүй байгаа энэ үед Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох найдвартай боломж бийг энэхүү компанийн бондын анхны арилжаа амжилттай болсноор илтгэсэн юм. ■




Манай сэтгүүл энэ удаагийн дугаартаа гадаадын хөрөнгө оруулалтын сэдвийг онцлон хөндлөө. Эдийн засагт ус, агаар мэт хэрэгтэй байгаа гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдал, гарц, шийдлийг хайсан нийтлэлүүд, тухайлбал, зээлжих зэрэглэл, бизнес боломжууд, олон улсын туршлага, хөрөнгө оруулагчдын нүдээр, тэд биднийг сонгох шалтгаан зэрэг сэдвийг онцлон хүргэж байна.

Яагаад Монгол...



Яг одоо

Э.Зоригт



Эдийн засаг хасах дүнтэй болчихоогүй. Өнөөдөр ч хасах руу ороогүй л байна. Гэсэн хэдий ч хямрал, уналт, удаашрал гэдэг үгээр өнөөгийн эдийн засгийн өнгийг тодорхойлж байгаа. Ард иргэд ч хямралын сургаар хямраад эхэлчихсэн. Тэгвэл хасах руу ороогүй эдийн засгийн хямрал монголчуудад яагаад хүндээр тусгаад байна вэ. Эдийн засгийн гол амьсгал болсон төлбөрийн тэнцэл, гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсантай холбоотой алдагдалд орсон нь ард иргэдийн хэтэвчийг дундалж байна. Энэ талаар Дэлхийн банкны ахлах эдийн засагч Таехюн Ли “Гадаадын хөрөнгө оруулалтыг эргэн татах бодлогын арга хэмжээ нь Монголын эдийн засгийн тогтвортой байдлыг дахин сэргээх гол арга зам” гэв. Ганцхан тоо дурдахад гадаадаас манай улсад орж ирдэг шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 44.3 сая ам.доллар болтлоо буурсан. Үүнтэй холбоотой өдгөө ам.долларын ханш



2000 төгрөгийн босго шүргэн алдаад байгаа. Ам.долларын амыг татах гэж Төвбанк валютын нөөцөө хайр найргүй дундалсаар. Тухайлбал, энэ оны эхний хагас жилд орж ирсэн гадаадын хөрөнгө оруулалт болох 44.3 сая ам.доллараас хоёр дахин их валютаар Монголбанк хагас сар хүрэхтэй үгүйтэй хугацаанд интервенц хийж ам.долларын ханшийг арай гэж барьж байна.

Гэхдээ гадаадын хөрөнгө оруулагчид Монголыг шууд орхисон уу гэвэл үгүй. Адаглаад өнгөрсөн долдугаар сард Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай 19 компани шинээр бүртгэгдсэн болохыг Улсын бүртгэлийн ерөнхий газар мэдээлжээ. Он гарсаар 130 гаруй гадаадын хөрөнгө оруулалттай компани улсын бүртгэлд бүртгэгдсэн аж.

Дээрээс нь уналттай эдийн засгийг сүүлийн үед өнгөлж байгаа нь Монголын хөрөнгийн биржийн сэргэлт юм. Тухайлбал, Монголын хөрөнгийн зах дахь хөрөнгө оруулагчдын идэвхи нэмэгдсэн гэдэг сайн мэдээ байна. Мэдээллээс харахад үнэт цаасны зах зээлийн арилжаанд гадаадын хөрөнгө оруулагчдын оролцооны идэвхийг энэ оны эхний долдугаар сарын байдлаар авч үзэхэд өмнөх оны мөн үеэс 2.5 дахин нэмэгдэж, 5.5 тэрбум төгрөгт хүрчээ. Мөн дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны идэвх өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28 дахин нэмэгдэж, нийт 323 тэрбум төгрөгт хүрчээ. /Дэлгэрэнгүйг графикаас харна уу/

Монгол улсад шинээр бүртгүүлсэн гадаадын хөрөнгө оруулалттай


АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО



Эх сурвалж Үндэсний статистикийн хороо

Үүнтэй зэрэгцээд Монголын банкуудын холбоо гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээнд дүн шинжилгээ хийснээ танилцууллаа. Харин тэдний хувьд Монгол Улсад хөрөнгө оруулах нөхцөл муу байна гэж дүгнэсэн байна. Учрыг нь тэдний гаргасан тайлангаас харна уу.

Олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурсан, Оюутолгой далд уурхайн санхүүжилтийн гэрээ хийгдсэн ч ТЭЗҮ-г батлах үйл ажиллагаа эхлээгүй байгаагаас гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт үргэлжилсээр байна. Оны эхний гурван сар хөрөнгө оруулалтын дүн хасах утгатай байсан ч Оюу толгойн гэрээ хийгдсэнээс үүдэн хүлээлт эерэг болж дөрвөөс зургадугаар сард нийт 86.6 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.



Хөрөнгө оруулалтын дүн өмнө оны мөн үетэй харьцуулахад -1065-р буурчээ.

	2012	2013	2014	2015.06
Жилийн бууралт	4.60%	-52.40%	-80.70%	-101.50%
Өмнөх оны мөн үетэй харьцуулахад	-40.23%	-34.44%	-104.27%	-106%

Эх сурвалж: Монгол банк

Бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоо 2014 оны эцсийн байдлаар 340 болж буурсан байна. 2012 оны гуравдугаар улирал хүртэл гадаадын хөрөнгө оруулагчид Монголд үйл ажиллагаа явуулж ашгийн дүнгээсээ дахин хөрөнгө оруулалт хийж байсан бол түүнээс хойш өнөөг хүртэл ашгаа Монголоос татжээ. Энэ нь хөрөнгө оруулагчид Монголын эдийн засгийн байдал, хууль эрх зүйн орчинд итгэх итгэл сул байгааг илэрхийлж байна. Өнгөрсөн зургаадугаар сард 3.6 сая ам.долларын орлогын дахин хөрөнгө оруулалт хийжээ.



Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын газар



Эх сурвалж: Монголбанк

Оюутолгой: Тус төслийн далд уурхайн санхүүжилтийн асуудал тавдугаар сард шийдэгдэж хөрөнгө оруулагчдын хүлээлт эерэг болсон. Харин ТЭЗҮ-г баталж, үйл ажиллагаа явуулж хөрөнгө оруулалт хийгдэх нь тодорхойгүй байна. TRQ-н гүйцэтгэх захирал Jeff Tygesen Оюутолгойн ТЭЗҮ-г есдүгээр сард баталж, далд уурхайн гэрээ болон нэмэлт тоонуудыг шинэчлэн батлуулах шаардлагатай байгаа хэмээн мэдэгджээ. Мөн тус компанийн зүгээс энэ онд капитал зарцуулалтанд 230 сая ам.доллар, үйл ажиллагааны мөнгөн зардалд нэг тэрбум ам.доллар байхаар төлөвлөсөн байна.

Тавантолгой: Удаан хугацаанд үргэлжилсэн хэлэлцээрийн үеэр талууд нийт 350 гаруй бүлэг асуудлыг тохиролцсон. Хэлэлцээний явцад Чалко компанид төлөх өрийн асуудал шийдэгдвэл Хөрөнгө оруулалтын гэрээ, Хамтын ажиллагааны гэрээ, Концессын гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанаар батлуулах төлөвлөгөөтэй байсан аж. УИХ-ын ажлын хэсгийн баг уг гэрээг хэрэгжүүлэх боломжгүй гэсэн дүгнэлт гаргаснаар гэрээний хэрэгжилт хойшилсон. Тус төсөл хэрэгжиж эхэлбэл дөрвөн тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх юм.

ДҮГНЭЛТ:

-Улс төр, хууль эрх зүйн тогтворгүй байдал нь хөрөнгө оруулагчдын зүгээс Монгол Улсад итгэх итгэлийг сэргээхэд томоохон бэрхшээл болж байна.

-Мега төслийн хэрэгжилт эхлээгүй, олон улсын зах зээл дээрх түүхий эдийн уналт үргэлжилж байгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй байхад голчлон нөлөөлжээ.

-Орлогын дахин хөрөнгө оруулалт хасах дүнтэй байгаа нь Монгол Улсад хөрөнгө оруулах нөхцөл муу байгааг илтгэж байна. Эх сурвалж: MVA

-Оюу толгой төслийн гэрээ хэлэлцээр эцэслэж, далд уурхайн бүтээн байгуулалт эхлэх хүртэл хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдэх нөхцөл бага байна.

Яг одоогийн нөхцөл байдал сайн муугийн дэнсэн дээр байгаа ч гадаадын хөрөнгө оруулагчид Монголыг хөрөнгө оруулалтын шинэ боломж хэмээн харсаар байгаа юм. Ялангуяа хөрөнгө оруулалтын ирээдүйг эерэгээр төсөөлж байна. /Яагаад гэдгийг манай сэтгүүлийн дараа дараагийн нийтлэлээс уншина уу/ Алдаанаасаа суралцсан монголчууд ч уул уурхайгаас бусад салбарт хөрөнгө оруулалт татахыг чармайж байна. Мөн томоохон төслүүдээ хөдөлгөхийг зорьж, хууль эрх зүйн хувьд ч дорвитой өөрчлөлтүүдийг хийсэн билээ. ■



UNCTAD

Хөрөнгө оруулалтын өлгий нутаг

Орчуулсан Б.Энхмөнх

Худалдаа хөгжлийн талаарх НҮБ-ын бага хурлын тайлангаас орчуулав.

Ази руу чиглэх гадаадын шууд хөрөнгө оруулалт хамгийн өндөр түвшинд хүрсэн жил байлаа хэмээн өнгөрсөн оныг онцолж байна. Учир нь, хөгжиж буй Азийг чиглэх Хөрөнгө оруулалт өнгөрсөн жил бараг хагас их наяд ам.долларт хүрчээ. Зүүн болон болон Зүүн өмнөд Ази руу чиглэх хөрөнгө оруулалтын урсгал 10 хувиар өсч 381 тэрбум ам.долларт хүрчээ. Харин дэлхий нийтийн Хөрөнгө оруулалтын урсгалыг авч үзвэл өнгөрсөн онд 14 хувиар буурчээ. 2013 онд 14.7 их наяд байсан урсгал 1.23 их наяд болжээ гэсэн үг. Хөрөнгө оруулалтын урсгалыг 2015 онд буцан сэргэж 1.4 их наяд ам.долларт хүрнэ гэж тооцолж байна.

Цаашлаад 2016 онд 1.5 их наяд, хоёр жилийн дараа 1.7 их наяд ам.доллар тус тус хүрнэ гэж үзэж байна. Ийнхүү тооцож байгаа шалтгаан нь АНУ-ын хөрөнгө оруулалтын либералчлал, таатай мөнгөний бодлого, газрын тосны хямд үнийг дагах эрэлт хэрэгцээ зэрэг өсөлтийн хандлагатай холбоотой юм. Мөн үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүдийн өндөр орлого болон хөрөнгийн нөөц зэрэг нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалыг өснө гэсэн хүлээлт үүсгэж буй аж.

Өнгөрсөн оны үзүүлэлтээс харахад хөгжиж буй Ази тив өсөлт үзүүлсэн бол Латин Америк руу хөрөнгө оруулалтын дотогшлох урсгал багасч харин Африкийн бүс нутагт өөрчлөлт гараагүй байна. Үүнээс үзэхэд Азийн бүс нутаг яах аргагүй гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах өлгий гэж ойлгож болох. Хөрөнгө оруулалт хүлээн авахаас гадна Ази нь дэлхийн хамгийн том хөрөнгө оруулагч бүс нутаг болжээ. Өнгөрсөн онд хөгжиж буй Азийн үндэстэн дамнасан компаниуд дангаараа 468 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг гадагш хийж өнгөрсөн оныхоос даруй 23 хувиар өссөн байна. Тэдний дэлхийд эзлэх хувь 35 хувь болж рекорд тогтоосон нь 2007 оныхтой харьцуулбал 13 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Түүхэнд анх удаа Азийн үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүд хамгийн том хөрөнгө оруулагчид болсон ба тэд нийт хөрөнгө оруулалтын бараг гуравны нэгийг эзэлсэн байна. Зүүн болон Зүүн Өмнөд Азийн эдийн засгийн өсөлт удааширч байгаа ч тус бүс рүү дотогшлох Хөрөнгө оруулалт

хүчтэй хэвээр байна. Дээр дурьдсанчлан Зүүн болон Зүүн Өмнөд Ази руу чиглэх хөрөнгө оруулалт өнгөрсөн онд 381 тэрбум ам.долларт хүрсэн нь түүхэн рекорд юм. Тус хоёр бүс нутаг аль аль нь өсөлттэй байсан бөгөөд Зүүн Азируу дотогшлох хөрөнгө оруулалт 12 хувиар өсч 248 тэрбум ам.доллар болсон бол Зүүн Өмнөд Азийнх таван хувиар өсч 133 тэрбум ам.доллар болжээ.

Азийн улсуудын үзүүлэлт тус бүр өөр байна. Тухайлбал, өнгөрсөн онд БНХАУ улс дэлхийн Хөрөнгө оруулалт хүлээн авалтаар тэргүүлэгч улс болж АНУ-ыг ардаа орхилоо. БНХАУ-руу дотогшлох Хөрөнгө оруулалт тус онд 129 тэрбум ам.долларт хүрч дөрвөн хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд голчлон үйлчилгээ тэр дундаа жижиглэн худалдаа, тээвэр болон санхүүгийн салбар том үүрэг гүйцэтгэсэн бол үйлдвэрлэлийн салбарын Хөрөнгө оруулалт буурсан байна. Үйлдвэрлэлийн салбарын бууралтын гол шалтгаан нь ажлын хөлс нэмэгдэж эхэлсэнтэй холбоотой. Хонг Конгийн Хөрөнгө оруулалт дотогшлох урсгал 39 хувиар өсч 103 тэрбум ам.доллар хүрсэн гайхалтай үзүүлэлтийг үзүүлжээ.

Харин өөр нэг дэлхийн санхүүгийн төв болох Сингапур улсын Хөрөнгө оруулалт дотогшлох урсгал ердөө дөрвөн хувиар өсч 68 тэрбум ам.доллар болсон байна. Харин манай Монгол Улсын хамрагддаг далайд гарцгүй хөгжиж буй орнууд дахь Хөрөнгө оруулалт гурван хувиар буурч 29 тэрбум ам.доллар болсон бөгөөд энэ нь гурав дахь жилдээ дараалан буурч буй үзүүлэлт юм. Далайд гарцгүй хөгжиж буй улсуудын хөрөнгө оруулалт хүлээн авагч топ таван улсын эгнээнээс Монгол Улс 76 хувийн бууралт үзүүлснээр хасагдаж Этиоп улс оронд нь орсон байна. Энэ бүлэг улсуудын үзүүлэлтэд Монгол Улсын огцом уналт том үүрэг гүйцэтгэж буй бөгөөд 2.1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татаж байснаас 508 сая ам.доллар болтлоо буурчээ. Тус улсын Хөрөнгө оруулалт дотогшлох урсгал дөрөв дахь жилдээ дараалан буурч байгаа юм. Улс төрийн болон бодлогын тогтворгүй байдал, саарч буй эдийн засгийн өсөлт нь хөрөнгө оруулагчдын сонирхолыг бууруулжээ. Монгол Улсын Хөрөнгө оруулалтын хэмжээг өсгөж болох магадлалтай нэг зүйл нь ОХУ болон БНХАУ-ын хооронд тавигдах хийн хоолойн бүтээн байгуулалт. Харин одоогоор Монгол Улсын Хөрөнгө оруулалт өсөлт суларсаар байна. ■

С.Жавхланбаатар: Хөгжиж буй орнууд дэлхийн нийт хөрөнгө оруулалтын 50 хувийг татдаг



З.Үжин

Бид энэ удаагийн ярилцлагын буландаа Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатарыг урилаа. Гадаадын хөрөнгө оруулалт буурч, төлбөрийн тэнцэл алдагдалд орж, ам.долларын ханш огцом өссөн энэ үед салбарын газрын дарга хөрөнгө оруулалтын ирээдүйг хэрхэн харж буйг сонирхуулья.

-Итгэл. Энэ үг хөрөнгө оруулагчдын хувьд хамгийн чухал. Гэтэл бид энэ итгэлийг өнгөрсөнтэй цуг алдчихсан. Тэгвэл тэдний итгэлийг буцаан олж авахын тулд юу хийх ёстой вэ?

-Ер нь хүний нийгмийн харилцаа тэр дундаа бизнесийн харилцаа итгэлцэл дээр оршдог. Тиймээс хөрөнгө оруулагчдын хувьд илтгэлцэл маш чухал. Энэ жилийн Эдийн засгийн чуулга уулзалт "Итгэлцэл" сэдвийн дор зохион байгуулагдсан нь цаг үеэ олсон гэж бодож байна. Бид мега төслүүдээ хэрэгжүүлж эхлэх нь гадны хөрөнгө оруулагчдад нааштай хандлагыг бий болгох чухал алхам гэж боддог. Ер нь

хэлэлцсэн, тохирсноо хэрэгжүүлдэг байх зарчим л олон улсын бизнест үйлчилдэг. Хэрэв чадахгүй бол цаашдын хамтын ажиллагаа, итгэлцлийн тухай яриад хэрэггүй биз. Бизнесийн итгэлцлийн асуудал шинжлэх ухааны онол, нийтлэг хэрэглээ болон хөгжиж байна. Анхны үүсэл нь XIX зууны сүүлээр Америкт хөрөнгө оруулагч тухайн бизнесийг өөрөө биш менежерүүдэд, менежментийн багт шилжүүлэн хийлгэдэг болсноор эхэлсэн. Засгийн газар, гадаадын хөрөнгө оруулагчийн итгэлцлийн асуудал хамтран байгуулж байгаа гэрээ, хэлэлцээрийн хүрээнд зохицуулагдаж байна.

Нэгэнт алдсан итгэлийг буцаан олж авах гэдэг асар үнэтэй, илүү их хүч хөдөлмөр шаардах нь тодорхой. "Нэр хугарахаар, яс хугар" гэж хоосон хэлээгүй байх. "The Mining Law Review" судалгаанд өгүүлснээр Монгол Улсын Засгийн газар хуулийн хүрээнд гэнэтийн шинэчлэл, өөрчлөлтүүдийг хийсээр буй бөгөөд энэ нь Монголын эдийн засгийн өсөлтөд зайлшгүй шаардлагатай

гадаадын хөрөнгө оруулалтын бууруулж буй голлох хүчин зүйл гэсэн байна лээ. Гэхдээ бид өөрсдийгөө бизнесийн найдвартай түнш гэдгээ харуулах томоохон боломжууд бий. гэж боддог. Тухайлбал, мега төслүүдийг эхлүүлэх, амжилттай хэрэгжүүлэхэд л бид нэр хүндээ буцаан олж авах боломж байна. Нөгөө талаас хөрөнгө оруулагчдын зүгээс үүргээ биелүүлэхгүй, зорилгоо буруу тодорхойлсон, соёл, ёс заншлыг үл ойшоосон асуудал цөөнгүй гардаг. Тэгэхээр итгэлцлийн асуудал нь оролцож буй талуудын эн тэнцүүгээр эрх үүргээ ухамсарлах ойлголт болов уу.

Мөн бизнес, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулахын тулд төр, хувийн хэвшил, иргэд хамтран ажиллах шаардлагатай байна. Монгол Улсад хөрөнгө оруулалт хийгээд бизнес эрхэлж байгаа компаниудын эрх ашгийг хамгаалах механизм бүрдүүлэхийн төлөө ажиллаж байна. Ингэснээр төрийн байгууллага болон хөрөнгө оруулагчдын хооронд үүсэх

үл ойлголцлыг бууруулж, дараа нь үүсэх сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байгаа юм.

-Хөрөнгө оруулалтын ирээдүйг хэрхэн төсөөлж байна вэ?

-Юун түрүүнд дэлхийн хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалт ямар дүр зурагтай байгааг товчхон дурдах нь зөв болов уу. НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурлаас жил бүр гаргадаг Дэлхийн хөрөнгө оруулалтын тайланд 2014 онд дэлхийн хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалт 16 хувь буюу 1,23 триллион ам.доллараар буурсан бөгөөд үүний цаад шалтгаан нь дэлхийн эдийн засгийн өсөлт удаашрах, улс орнуудын хөрөнгө оруулалтын бодлого тодорхой бус байх, эцэст нь геополитикийн шинж чанартай асуудлууд гэсэн үндсэн гурван шалтгааныг тус тайланд нэрлэжээ байгаа. Харин бүс нутгийн хэмжээнд аваад үзэхээр эдийн засгийн хувьд чадавхитай хөгжилтэй улсууд руу чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт 28 хувиар унасан харин Монгол шиг хөгжиж буй далайд гарцгүй улс орнууд руу чиглэсэн хөрөнгө оруулалт гурван хувиар унасан дүр зураг ажиглагдаж байна.

Дэлхийн хэмжээнд хөрөнгө оруулалтын хандлага нэмэгдэх таамаглалтай байгаа бөгөөд 2015 онд 11 хувь буюу 1,4 триллион ам.доллар, 2016 оны 1,5 триллион ам.доллараар нэмэгдэх судалгааг зарим байгууллага гаргасан байна. Мөн Хятадын эдийн засгийн удаашрал Ази тивийн бусад улс орнууд руу чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх таамаглал байдаг. Гэхдээ нөгөө талаас хөгжингүй орнуудад өөрсдийн үндэстэн дамнансан корпорациудыг дотооддоо буюу үүсгэн байгуулагдсан эсхүл ихэнх хувийг эзэмшдэг улсдаа шууд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, ажлын байр тэлэх бодлогыг явуулж байна.

Монгол Улсын хувьд ирээдүйг мэдээж өөдрөгөөр төсөөлж байна. Энэ нь дэлхийн эдийн "аясаар" гэхээс илүү биднээс шууд хамааралтай. Хөрөнгө оруулалт татах чиглэлээр олон ажил хийгдэж байгаа. Цаашид ч улам эрчимжүүлэх шаардлагатай. Энэ нь өөрөө нийгэм, эдийн засгийн бүхий л салбарыг хамардаг. Гудамжинд явж байгаа гадаад хүний аюулгүй

байдал хэрхэн хангагдаж байгаа, бид тэдэнд хэрхэн хандаж байгаагаас эхэлнэ. Хамгийн чухал нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж, давуу талууд бидэнд байна. Эдийн засаг нь өөрөө 10 тэрбум ам.доллараар хэмжигдэж байхад шаардлагатай дэд бүтцийн төслүүд багаар тооцоход 30 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардаж байна. Эдгээр төслийг эрэмбэлж, нарийн төлөвлөгөөтэй хэрэгжүүлбэл эдийн засгаа хурдацтайгаар, тогтвортой тэлэх боломж байна. Энэ хүрээнд төр, засгаас хөрөнгө оруулагчдад илүү найдвартай эрх зүйн орчин, баталгааг бүрдүүлэх зорилгоор Хөрөнгө оруулалт, Концессын гэрээ байгуулах зэрэг шинэ механизмуудыг бүрдүүлэн ажиллаж байгаа. Гэхдээ энэ нь хангалттай гэсэн үг биш, нэмж сайжруулах, баталгаа гаргах зэрэг олон улсад ашигладаг, эсхүл хөрөнгө оруулагчийн зүгээс тавьдаг зарим арга хэрэгсэл одоо ч дутуу байна.

-Сүүлийн жил гаран монголчууд хөрөнгө оруулагчдыг татах талаар ярилаа. Нөгөө талдаа чанартай хөрөнгө оруулагчтай болохын тулд манай талаас ямар шаардлага тавьж байгаа вэ?

-Мэдээж манай бодлого аль болох Монголд хөрөнгө үлдээе, хөрөнгө оруулалтыг шингээж, хоёр талдаа ашигтай байхыг чухалчилдаг байгаа. Судалгаагаар хөгжиж буй орнууд дэлхийн бүх хөрөнгө оруулалтын 50 хувийг шууд өөртөө татдаг. Америк улс хөрөнгө оруулалтыг татах чадвар, хэмжээгээр тэргүүнд явдаг. Учир нь эдийн засгийн өөрийн амин хэлхээ нь хөрөнгө оруулалт болчихсон схемтэй.

Гол нь тухайн улсаас гадагш хийж байгаа хөрөнгө оруулалтыг бас тооцох асуудал хөндөгдөнө. Бид өөрсдөө тоглоомын дүрмээ тодорхой байлгаж, өөрт ашигтай хөрөнгө оруулалтын төслийг хамтран амжилттай хэрэгжүүлэхийг эрмэлзэх хэрэгтэй болов уу. Энэ тохиолдолд хөрөнгө оруулалтын болон хөрөнгө оруулагчийн чанарын асуудал дагаад сайжирна гэж бодож байна.

Энэ оны эхний зургаан сарын байдлаар нийт 524 сая ам.долларын хөрөнгө оруулалт бүртгэгдсэн байна.

Уул уурхайн хэт өсөлт огцом буурсан

нь Монгол Улсад 2011-2012 онуудад орж байсан огцом хөрөнгө оруулалтыг багасгасан. Энэ нь харин гадна талдаа ч дотоодод ч хөрөнгө оруулалтын төрөлжилт болон чанарын асуудалд анхаарах боломжийг бидэнд олгосон байна. Шинэ хөрөнгө оруулалтын хуулийн мөрдөн хэрэгжүүлж буй 20 сарын хугацаанд бидний зохион байгуулсан арга хэмжээнүүд, хэлэлцсэн, дэмжлэг үзүүлсэн төслүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд уул уурхайн бус салбарууд дийлэнх хувийг эзэлж байгаа юм.

Нөгөө талаас хөрөнгө оруулагчийн чанарыг шалгах гол нөхцөл түүний туршлага, чадавхиас гадна санхүүжилт босгох чадвар байдаг. Өөрөөр хэлбэл, санхүүжилтийн арга хэрэгслээ тодорхой байлгах шаардлагыг бид тавьж байгаа. Ихэнх тохиолдолд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид эхлээд төрөөс шийдвэрийг нь гаргуулчих гээд явдаг. Шийдвэр гарсан хойно санхүүжилт бүтэхээ байчихлаа гээд эргээд ирнэ. Энэ нь төслийг хэрэгжүүлэх бэлтгэл болон яриа хэлэлцээний эхнээс нь дуустал нь санхүүжүүлэгчээ хамруулах, мэдээллээр хангах ажлыг орхигдуулсантай холбоотой.

-Тоглоомын дүрэм тодорхой боллоо. Хөрөнгө оруулалтын орчин сайжирлаа гэж байгаа. Тэгвэл энэ талын хуулийн хэрэгжилт хэр байгаа бол?

-Шинээр баталсан Хөрөнгө оруулалтын тухай хууль нь бодлогын болон тогтолцооны хувьд томоохон өөрчлөлт гарсан гэж хэлж болно. Өмнө үйлчилж байсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Стратегийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулиуд нь онолын хувьд хянах, зөвшөөрөл олгоход чиглэж байлаа. Харин шинэ хуулийн тогтолцоо нь илүү либериал, бизнест ээлтэй байх зохицуулалтыг агуулснаараа онцлогтой. Мөн шинэ хуулинд зөвшөөрлийн тогтолцоог багасгах, бууруулах, хөрөнгө оруулалтын бодит үр ашгийг тогтоох, эдийн засгийн төрөлжилтөд дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтын тодорхой хөшүүрэг дэмжлэгийн механизмыг тусгасан. Хуулийг баталсан өдрөөс эхлэн Засгийн газраас хууль сурталчлахад анхаарч, цуврал арга



С.Жавхланбаатар: Хөрөнгө оруулагчид шинэ хуульд ам сайтай байгаа.

хэмжээнүүдийг гадаад болон дотоодод зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээг энэ онд үргэлжлүүлэн хийнэ.

Хөрөнгө оруулагчид шинэ хуульд ам сайтай байгаа. Гэхдээ бодит үр дүнг хүртэхэд тодорхой хугацаа шаардагдана.

Хөрөнгө оруулагчдад өгч байгаа гол мессэж юу вэ?

-Манай газрын хувьд заавал хийх ёстой ажлуудын нэг бол нэгэнт Монголд ирчихсэн байгаа хөрөнгө оруулагчдад анхаарах асуудал байдаг. Олон улсын судалгаагаар аливаа улсад тухайн жилд орж байгаа хөрөнгө оруулалтын 50-60 хувийг өмнө нь хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчид дахин оруулсан байдаг. Тиймээс хөрөнгө оруулагчдад тулгарах асуудлыг багцлах ажил эхлээд байгаа.

Түүнээс гадна өмнө нь хоёр сар болж байж компани байгуулдаг байсан бол одоо мөрдөгдөж буй хуулиар 5-10 хоног хангалттай.

Шинээр баталсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн үндсэн хүчин зүйлс нь илүү чөлөөтэй зах зээлийн нөхцөл, бизнесийн таатай орчин, үр ашигтай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэсэн юм. Мөн гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг ижил түвшинд хамгаалж, бодит татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхээр тусгаж өгсөн.

Тухайлбал, хуульд заасан тодорхой шалгууруудыг хангасан Хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд Тогтворжуулах

гэрчилгээ олгож Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Гаалийн албан татвар, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /Роялти/ гэсэн эдгээр татварыг 5-24 жилийн хугацаанд хувь, хэмжээг нь тогтвортой байлгах юм. Хөрөнгө оруулагчдын хувьд татварын хувь, хэмжээг бууруулах, татвараас чөлөөлөх асуудлаас илүүтэйгээр татварыг тодорхой хугацаанд, ялангуяа төслийн бүтээн байгуулалт хийх үед, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаанд тогтвортой байлгах нь томоохон дэмжлэг болохоор харагдаж байна.

Засгийн газраас сүүлийн хоёр жил хагасын хугацаанд хөрөнгө оруулалтын бодлогоо гаргаад, хуульчлаад олон улсад таниулах ажлыг хийлээ. Монголын хөрөнгө оруулалтын орчин өөрчлөгдөж байна гэдгийг таниулах ажлыг нэлээдгүй хийж, өнгөрсөн онд 70 гаруй, 2015 оны эхний найман сарын байдлаар 20 гаруй бизнес форум, хөрөнгө оруулалтын чуулга уулзалтуудыг дотоод гадаадад зохион байгууллаа.

ДХБ, НҮБ болон хөрөнгө оруулагчдаас сайн үнэлгээ авсан. Гэхдээ хэрэгжилт, гүйцэтгэл хамгийн чухал. Мөн бид дэлхийд түршигдаад амжилттай болсон үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхээр ажиллаж, хөрөнгө оруулагч нарт мэргэжлийн мэдээлэл, бодит зөвлөгөөг өгч байна.

Одоо салбар бүр дээр Хөрөнгө оруулалтын хуулийг дагаад суурь бодлогыг хэрхэн тусгах, хэрэгжүүлэхэд

анхаарч байгаа.

Тухайлбал, Газрын тос, Ашигт малтмалын хуулийг шинэчилсэн нь уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдыг хөдөлгөж эхэллээ. Энэ нь мөн газар тариалан, хөдөө аж ахуй, мал аж ахуй, эрүүл мэнд, боловсрол гээд бүх салбарт хэрэгжих учиртай.

-Та ам.долларын өсөлтийг юу гэж тайлбарлах вэ?

Ам.долларын ханшийн өсөлтийн шалтгааныг гадаад валютын нөөц багассантай холбон тайлбарлаж байна. Гадаад валютын нөөц аливаа улсад орж ирэх үндсэн хоёр суваг байдаг. Эхнийх нь экспорт, нөгөө нь гадны шууд хөрөнгө оруулалтыг татах чадвартай холбоотой. Тэгэхээр долларын ханшийн өсөлтийн ард буй нэг шалтгаан нь валютын нөөц мөн үү гэвэл мөн.

Гэхдээ энэ нь валют орж ирэхгүй байгаагийн шалтгаан нь юу вэ гэдгийг бодоход хүргэнэ. Ам.долларын ханшны өсөлт бууралт эдийн засгийн нэг илэрхийлэгч. Зүрхний бичлэгээр яривал нэг давтамж гэсэн үг. Гэхдээ зүрхний цаад өвчний шалтгааныг илэрхийлэгч биш.

Товчхондоо, экспортоо нэмэгдүүлэхийн тулд бид дотооддоо үйлдвэрлэх шаардлагатай. Шууд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхийн тулд бизнесийн орчноо улам бүр сайжруулах, салбар бүрт хэрэгжүүлэх бодлогоо, төслөө тодорхой болгох хэрэгтэй байна. ■



ЗАХ ЗЭЭЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

“ ГАДААД ХУДАЛДААНЫ МЕНЕЖЕР БЭЛТГЭХ ” 3 САРЫН ЭРЧИМЖҮҮЛСЭН СУРГАЛТАНД ЭЛСЭЛТЭЭ АВЧ ЭХЭЛЛЭЭ



БҮРТГЭЛ ЭХЛЭХ ХУГАЦАА: 2015 оны 8 сарын 05

Зах Зээл Судлалын Хүрээлэн нь 1994 оноос Гадаад худалдааны менежер бэлтгэх сургалтыг явуулж эхэлсэн бөгөөд аж ахуйн нэгжүүдийн гадаад худалдааны менежерүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, экспорт, импортын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудыг гадаад худалдааны чиглэлээр төгс мэргэшсэн, онол, практикийн өндөр мэдлэг чадвартай хүний нөөцөөр тасралтгүй хангах зорилгоор 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн “ ГАДААД ХУДАЛДААНЫ МЕНЕЖЕР БЭЛТГЭХ ” 3 сарын эрчимжүүлсэн сургалтын БЯМБА гаригийн болон ОРОЙН ангид аа элсэлтээ авч эхэллээ.

ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ

- 1. Гадаад худалдааны менежмент**
 - Экспортын маркетинг
 - Импортын менежмент
- 2. Олон улсын худалдааны эрхзүй**
 - Олон улсын худалдааны гэрээ байгуулах
 - Маргаан шийдвэрлэх
- 3. Гадаад худалдааны төлбөр тооцоо**
 - Аккредитив
 - Инкасс
 - Гадаад худалдааны баримт бичгүүд
- 4. Гадаад худалдааны санхүүжилт**
 - Дотоод эх үүсвэртэй санхүүжилт
 - Гадаад эх үүсвэртэй санхүүжилт
- 5. Ложистик, гадаад худалдааны тээвэрлэлт**
 - Инкотермс 2010
 - Нийлүүлэлтийн гинжин хэлхээ
- 6. Гадаад худалдааны тээвэрлэлтийн даатгал**
 - Даатгалын нөхцлүүд, эрсдэл, үнэлгээ
 - Ачаа тээвэрлэлтийн даатгалын олон улсын нөхцөл
- 7. Экспортын зардал, үнэ бүрдэлт**
 - Экспортын барааны үнэ бүрдэлт
 - Экспортын зардлын онцлогууд
- 8. Олон улсын худалдааны зохицуулалт**
 - Дэлхийн худалдааны байгууллага
 - Тарифын болон тарифын бус хориг саадууд
- 9. Олон улсын хэлэлцээр**
 - Хэлэлцээр хийх үе шат
 - Хэлэлцээрийн тактик, стратеги
- 10. Гааль**
 - Гаалийн хяналт, гаалийн бүрдүүлэлтийн горим
 - Гаалийн үнэлгээ
- 11. Валютын ханшны эрсдлийн менежмент**
 - Валютын ханшны эрсдлийн хүчин зүйлс
 - Эрсдлээс хамгаалах санхүүгийн үүсмэл ба үүсмэл бус аргууд
- 12. Нийт**

ЦАГ

- 12
- 10
- 14
- 12
- 16
- 8
- 10
- 8
- 10
- 10
- 10
- 10
- 10
- 120



СУРГАЛТЫН ХУГАЦАА:

**2015 оны 9 сарын 19-нөөс 12 сарын 05 /Бямба гаригийн анги/
2015 оны 9 сарын 15-наас 1 1 сарын 19 /Оройн анги/**

ХИЧЭЭЛЛЭХ ЦАГ:

**09.30-18.20 /Бямба гаригийн анги/
15.00-19.50 / Оройн анги/**

МАНАЙ СУРГАЛТЫН ОНЦЛОГ:


- Богино хугацаанд гадаад худалдааны чиглэлийн практик давамгайлсан цогц мэдлэг олгоно.
- 20 гаруй жил гадаад худалдааны чиглэлээр хичээл заасан туршлагатай багш нар сургалтыг хөтлөн явуулна.
- Анги дүүргэлт цөөн хүнтэй.
- Ажлын бус цагаар хичээллэнэ.
- Бямба гаригийн анги 7 хоног бүрийн зөвхөн "Бямба гаригт хичээллэнэ."
- Оройн анги 7 хоногт 2 удаа (Мягмар, Пүрэв гариг) хичээллэнэ.
- Гарын авлага, тараах материалыг онлайн хэлбэрээр өгнө.
- Англи, монгол хавсралт бүхий сертификат олгоно.

ХОЛБОО БАРИХ УТАС:

88870404, 9983-3670

ХАЯГ: Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Соёлын Төв Өргөө, "Г" Корпус, 422 тоот, Зах Зээл Судлалын Хүрээлэн

Яагаад Монгол...



1. Авлигагүй Монгол

Ийм зорилгыг өмнөө тавьсан монголчууд сүүлийн хэдэн жил авлигыг бууруулахад багагүй амжилт үзүүлээд байгаа. Тухайлбал, дотооддоо Авлигын индексийг тооцох судалгааг гаргаж олон нийтэд мэдээлсэн. Уг судалгааг 2009 оноос хойш хоёр жил тутам гаргаж байгаа юм. Хамгийн сүүлийн тайлангаас харахад төрийн албан хаагчтай холбоотой авилгын гэмт хэрэг 22 хувиар буурчээ. Гэхдээ иргэд, аж ахуйн нэгжтэй холбоотой авилга 14 хувиар нэмэгдсэн байна. Харин нийт дүнгээрээ Монгол улсын авилга тасралтгүй буурсаар байгаа юм. Үүнийг олон улсын Транспаренси Интернэшнл байгууллагаас гаргасан судалгаа ч баталж буй. Тухайлбал, өнгөрсөн жил Монгол улс 39 оноотойгоор 175 орноос 80 дугаар байранд жагсчээ. Манайхтай цуг Марокко, Эль Сальвадор улсууд 80 дугаар байранд эрэмбэлэгдсэн. Монгол 2012 онд 94 дүгээр байр, 2013 онд 83 дугаар байранд бичигдэж жил дараалан авлигын индекс сайжирсан үзүүлэлттэй гарчээ.

2. Ардчилсан Монгол

Монгол Улсыг гадаадын хөрөнгө оруулагчид сонгох хамгийн чухал шалтгааны нэг бол яах аргагүй ардчилал бөгөөд чөлөөт эдийн засаг юм. Монголчууд ардчилалыг сонгоод 25 жилийг ардаа үдсэн. “Эдийн засгийн өрнөл ба улс төрийн замнал” илтгэлд “Евроазийн эх газрын дунд эрх чөлөөт бус улс орнуудаар хүрээлүүлсэн Монгол Улс Фрийдомхаусын газрын зураг дээр яг л цэлэлзсэн хөх далайн дундах ногоон арал шиг харагддаг” гэжээ. Магадгүй Монгол бол таны хөрөнгөө оруулах ногоон арал ч юм билүү.

3. Ашигтай Монгол

Монгол оронд 80 төрлийн ашигт малтмалын 1170 орд найман мянга гаруй илрэл бүртгэгдсэн байдаг. Үүнд алтны 1619, мөнгөний 227 мянга, зэсийн 36.3 сая, төмрийн хүдрийн 660 сая, цайрын 5.9 сая, нефтийн 250 сая орчим тонн нөөц батлагдаад буй. Мөн нүүрсний 175 тэрбум тонн таамаг нөөцтэй. Эдүгээ 9.8 тэрбум тонн нөөц баталгаажсан.

Нөөц ихтэй томоохон ордыг нэрлэвэл зэсийн Эрдэнэт, Оюу толгой, Цагаан суварга, алтны Гацуурт, Тавт, мөнгөний Асгат, Мөнгөн өндөр, төмрийн хүдрийн Баянгол, Төмөртэй, Төмөртэйн овоо, Баргилт зэрэг юм. Монгол Улсын нийт экспортын 94 хувийг ашигт малтмал эзэлж байна. Мөн Төмрийн хүдрийн таамаг нөөц 11 тэрбум тонн, Нүүрсний нөөцөөр дэлхийд эхний 15 дугаар байрт орж байна.

1. Дэд бүтцийн томоохон төсөл хөтөлбөр

Монгол Зөвхөн уул уурхайн асар их баялагтай түүнийгээ олборлохын тулд л хөрөнгө оруулагчдыг “Тавтай морил” хэмээн угтаагүй. Уул уурхайгаас гадна хөгжиж байгаа орны хувьд дэд бүтэц болон эрчим хүчний салбарт томоохон хөрөнгө оруулалт татах бүрэн боломжтой юм.

-Шинэ төмөр зам, Шинэ нисэх буудал, Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл, Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслүүд

<http://mrt.gov.mn/all/28>

-Дэд бүтэц, барилга байгууламжийн төслүүд.

http://www.med.gov.mn/mn/images/kontsess/kontsessin_zuiliin_jagsaalt.pdf

-Эрчим хүчний төслүүд

<http://energy.gov.mn/content?t=4>

- Барилгын төслүүд


www.mcup.gov.mn/pages/604

<http://news.barilga.mn/tender>

2. Дэлхийн хамгийн хурдтай өсч буй эдийн засаг

Монгол Улсын эдийн засаг 2011-2013 онд онцгой дэвшил гаргасан бөгөөд дунд хугацааны хэтийн төлөв өөдрөг байгаа юм. Энэ хоёр жилийн хугацаанд дэлхийд хамгийн хурдан өсч буй эдийн засаг болж, ядуурлын түвшин 11.3 хувиар буурчээ. Энэ онд ДНБ өсөлт огцом саарсан ч хасах руу ороогүй байна.

ДНБ-ий өсөлт. хувиар
(үйлдвэрлэлийн аргаар. 2010 оны зэрэгцүүлэх үнээр. өмнөх оны мөн үеийнхээс)



3. Дэлхийн хоёр том эдийн засгийн дунд оршдог

Монгол орон нь өмнөд хэсгээрээ БНХАУ-тай хойд хэсгээрээ ОХУ-тай хэлэлдэг. Энэхүү газар зүйн өвөрмөц байршил нь Монголд аливаа бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн хоёр том зах зээлд нийлүүлэхэд хамгийн дөт зам байх боломжийг бүрдүүлж өгдөг. Эрт дээр үеэсээ худалдаа наймааны дамжин өнгөрөх хамгийн дөт зам байсаар ирсэн. Өдгөө ч тэр хэвээрээ, дамжин өнгөрөх аюулгүй, нээлттэй тунель болсоор байна.

Үлдсэн гурван боломж

1. Монгол баян

Баян гэдгийг батлах өөр нэг тоон үзүүлэлт бол нэг хүнд ноогдох газар нутгийн болон малын хэмжээгээр дэлхийд дээгүүрт ордог. Тийм ч учраас уул уурхайгаас гадна хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт татах өргөн боломж бий.

Нийт малын тоо толгой: Өнгөрсөн оны эцсийн дүнгээр манай улсын нийт малын тоо 52,0 саяд хүрчээ.

Нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээ: 0.6 км²

2. Татварын хэмжээ бага

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, татвар, бизнесийн таатай орчин бүрдүүлэх талаар төр засгаас шат дараалсан


арга хэмжээ авсаар байна. Үүний үр дүнд Монгол Улс Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд бага татвартай, хөрөнгө оруулахад таатай орны тоонд зүй ёсоор багтдаг.

Нийт хэдэн төрлийн татвартай, тэдгээрийн хувь хэмжээ..

- Хүн амын орлогын албан татвар 10%
- Аж ахуй нэгжийн орлогын албан татвар 10%
- Гаалийн татвар 5%
- Нэмүү өртөгийн орлогын албан татвар 10%
- Онцгой албан татвар ...

3. Хууль эрх зүйн шинэ, илүү таатай орчин

Монгол Улс Хөрөнгө оруулагчийг хамгаалах эрх зүйн тогтолцоогоор дэлхийд эхний 21 дүгээр байрт ордог талаар Хөрөнгө оруулалтын газраас мэдээлсэн. Дээрээс нь улс төрийн тогтворгүй байдлаас болж хөрөнгө оруулагчдийг үргээсэн засаг алдаагаа засах үүднээс УИХ-аас 2013 оны 10 дугаар сард Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталсан. Уг хуулиар гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг ижил түвшинд хамгаалж, бодит татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхээр тусгаж өгсөн. Үүний нэг томоохон дэмжлэг нь хуульд заасан тодорхой шалгууруудыг хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд Тогтворжуулах гэрчилгээ олгож, ААНОАТ, НӨАТ, АМНАТ, гаалийн албан татварыг 5-24 жилийн хугацаанд хувь, хэмжээг нь тогтвортой байлгах юм. ■



Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын газар

БАЯЛАГ хадгалагчид

Б.Үүрийнтуяа

Байгал эхийн нөөцөөр баялаг гурван улс дэлхийн эдийн засагт нэгэн цоо шинэ ойлголтыг авчирсан юм. МЗ гэж нэрлэгдэх болсон эрдэс баялгийн арвин их нөөцтэй гурван улс болох Монгол, Мьянмар болон Мозамбик нь дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй эдийн засаг гэгдэж байна. Уг гурван улс газар зүй болон эдийн засгийн хувьд аль алианаар нь "BRICS"-ийн (Бразил, Орос, Энэтхэг, Хятад, Өмнөд Африк) орнуудтай нягт холбоотой ба гайхалтай хөгжлийн хурдыг харуулснаар дэлхий нийтийн анхаарлыг татаж чаджээ. Энэ зууны Торгоны Зам гэгдэх болсон МЗ-ын улсууд ирэх арван жилд хамгийн хурдан өсч буй улсын тоонд багтах төлөвтэй байгаа. Монгол Улс жилд 15 хувийн ДНБ-ий өсөлттэй байх төлөвтэй байгаа бол Мьянмар болон Мозамбик улс 12 болон 10 хувийн өсөлттэй байх болно хэмээн тооцоолж байна. "Silk Road Management" фирмийн удирдах түнш Алишер Али "Бид хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулагчдад МЗ гэсэн ойлголтыг шинэлэг хөрөнгө оруулалт хэлбэрээр танилцуулж байгаагаараа бахархаж байна. Монгол, Мьянмар болон Мозамбик улс зарим талаараа маш адил төстэй бөгөөд эдгээр улсын эдийн засаг хөрөнгө оруулагчдад гайхалтай боломжийг олгох болно гэдэгт итгэлтэй байна" хэмээн дурдсан байна. "Тиймээс анх удаа Монгол, Мьянмар болон Мозамбик улсад голчлон чиглэсэн хөрөнгө оруулалтын сан болох Торгоны Зам МЗ санг байгуулсан юм. Уг сан гол төлөв тус гурван улсад хөрөнгөтэй, үйл ажиллагаа явуулж буй олон улсад бүртгэлтэй компаниудын хувьцаанд, түүнчлэн өндөр орлоготой тогтмол хөрөнгө оруулалт болон орон нутгийн валютын хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх болно" гэж тэрбээр нэмж хэлэв.



Монгол

Нүүрсний могул Монгол Улс томоохон нүүрс, зэс, алт болон бусад ховор ашигт малтмалын ордны ачаар байгалийн баялгийн хүчтэй тоглогч өндөр магадлалтай. Арваад жилийн өмнө Монгол Улсын ДНБ-ий хэмжээ ердөө 500 ам.доллар байсан төдийгүй Азийн хамгийн ядуу таван орны нэгд тооцогдож байсан бол 2012 он гэхэд ДНБ-ий хэмжээ нь 3,000 ам.доллар болтлоо огцом нэмэгджээ. Өнөөдөр Монгол Улс олон улсын хөрөнгө оруулагчдын дунд өндөр эрэлттэй улс болсон аж.



Мьянмар

Шинэ зах зээл

Мьянмар улс түгжигдмэл улсаас хамгийн чинээлэг бизнес болон санхүүгийн зах зээл болж өөрчлөгдөх түүхэн хувьсалын үе шатанд явж байгаа ба тус улсын эдийн засагт хөрөнгө оруулалт үнэхээр их шаардагдаж байна. Дэлхийн хамгийн өндөр зэрэглэлийн бадмаараг болон сафирийн нөөц, Зүүн Өмнөд Азийн хоёр дахь том газар нутаг болон 60 сая хүн амтай Мьянмар улс дэлхийн хамгийн анхаарал татсан хөрөнгө оруулалтын боломжуудын нэг төдийгүй өндөр аутсорсингийн хүчин чадал бүхий улс юм



Мозамбик

Аж үйлдвэрийн магнат

Иргэний дайн, улс төрийн тодорхойгүй байдалтай тэмцэж ирсэн Мозамбик улс сүүлийн арван жилийн хугацаанд эдийн засгийн асар их амжилт олжээ. Хөгжиж буй аж үйлдвэрийн салбарынхаа ачаар сүүлийн хэдэн жилд эдийн засгийн өсөлт нь 10-аас доошгүй хувийг үзүүлсэн юм. Уг өсөлт тус улсын хөдөө аж ахуй, харилцаа холбоо болон аялал жуулчлалын салбарт үр дүнгээ хамгийн ихээр өгчээ. ■



1990 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн ОХУ-ын "Zalan Energy" компанийн Ерөнхий захирал Р.Чингистэй ярилцлаа. Тус компани нь барилга,цахилгаан хангамжийн бараа, бүтээгдэхүүний борлуулалт хийдэг бөгөөд хойд хөршийн зах зээл дээр сүүлийн 15 жил амжилттай яваа юм. Тэдний хувьд хилийн чанад дахь анхны зах зээл нь Монгол.

-Таныг Монголын зах зээлд орж ирэхэд юу хөтөлсөн бэ?

-Монгол руу орж ирсэн шалтгаан нь хямрал. Хямрал бол шинэ боломжийг нээдэг. ОХУ-д маш том хямрал болж байна. Хэдий Монголын эдийн засаг хүндрэлтэй байгаа ч энэ нь бидний хувьд шинэ боломж. Хямрал боллоо гээд хойш суух биш илүү шинэ хязгаарт хүрч, шинэ боломжийг нээх гэж Монгол руу орж ирсэн. ОХУ-ын Ерөнхийлөгч Монголд ирэхдээ хамтын ажиллагаагаа илүү өргөжүүлж, бэхжүүлж буйгаа хэлсэн. Манай төв компани Буриадад бий. Ахан дүүс болсон улсдаа үйл ажиллагаа явуулахаар шийдэж дөнгөж энэ онд Улаанбаатар хотод салбар компани байгуулаад байна. Монголын эдийн засаг бага үзүүлэлттэй байсан ч огцом өссөн. Нэг талаас энэ нь Монголд орж ирэх бас нэг шалтгаан болсон гэж болно.

-Шинэ хөрөнгө оруулагчийн хувьд Монголын зах зээлд орж ирэхэд хүндрэлтэй зүйл юу байв. Одоогоор саад тотгор болж байгаа зүйл байна үү?

-Монгол бизнес эрхлэхэд маш нээлттэй, нөхөрсөг орон. Гэтэл Орос

Монголд орж ирсэн шалтгаан бол хямрал

Г.Орхон

улсад бизнесийн хамтрагч, харилцагчид ингэж нээлттэй байдаггүй. Ганц уулзахаар "Чи хэн юм бэ. Миний хувийн юманд битгийн халд" ухааны юм ярьдаг. Бид өнөөдөр Монголд хямралаас өөр ямар ч хүнд зүйл олж харахгүй байна. Бүх зүйл боломжийн нээлттэй байна. Эдийн засаг өсч, буурч циклээр явдаг учир Монголын одоогийн эдийн засгийн байдал аль ч оронд байдаг л зүйл. Ирэх жилээс эдийн засаг сайжирна гэж найдаж байна. Ийм нөхцөлд бидэнд худалдан авагч харьцангуй олон байгаа. Тийм учраас нэг ширхэг гэрлийн чийдэн худалдаж авч байгаа хүн ч гэсэн бидний хувьд маш чухал.

-Таны хувьд Монголын хөрөнгө оруулалтын орчныг аль өнцгөөс нь харж байна вэ?

-Ямар ч асуудал гаргахгүйгээр бүх зүйлийг хуулийн дагуу хийх хэрэгтэй. Монголын хөрөнгө оруулалтын орчинд ямар нэгэн асуудал олж харахгүй байна. Зорилгодоо хүрэхийн тулд бүх зүйлийг хуулийн дагуу хийх хэрэгтэй. Оросоос хөрөнгө оруулалт татахад бүх зүйл нээлттэй. Учир нь, тэнд чинээлэг бизнесмэн олон бий. Тиймээс тэднийг Монгол руу татах зүйл хийвэл хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Хөрөнгө оруулагчид зах зээлээ сайн судалж байж орж ирвэл ямар нэгэн асуудал гардаггүй. Гол нь ОХУ-д хямрал нүүрлэж, рублийн ханш унасан. Ингэснээр Оросын бараа, бүтээгдэхүүний үнэ буурч байна. Тиймээс оросын чанартай барааг хямд үнээр худалдан авах боломж монголчуудад байна.

-Оросын хөрөнгө оруулалтын орчинд манайхаас өөр ялгаатай зүйл байна үү?


-Хоёр улсын эдийн засгийн бүтэд ерөнхийдөө адилхан. Монгол газрын баялагаа борлууж байхад Орос ч ялгаагүй нефтээ худалдаалдаг. Манай улсад газрын тосны үнэ унаснаар хямрал эхэлсэн. Монголд мөн адил иймэрхүү бүтцээр хямрал болсон. Энэ

хямралаас бага алдагдалтай гарахын тулд үндэснийхээ бүтээгдэхүүнээ урд, хойд хөрш орнууд руу худалдаалах нь зөв. Бид "Эрдэнэт Лед" гэх монгол компанитай хамтарч ажиллахаар ярилцаж байна. Энэ компанитай хамтарч ажилласнаар Монголын бүтээгдэхүүнийг Монголд гэлтгүй Оросын зах зээлд борлуулна. Хэрэв уг компанийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг бид борлуулж, монголчууд дотоодын бүтээгдэхүүнээ авснаар энэ компанийн эрэлт ихэснэ. Ажилчдын тоо нь нэмэгдэж, илүү олон хүн ажлын байртай болно. Мөн улсад татвар төлснөөр улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх юм.

-Хөрөнгө оруулалтын орчноо сайжруулахын тулд Засгийн газар юу хийх хэрэгтэй гэж та бодож байна вэ?

-Монголын Засгийн газар гадаад иргэд болон хөрөнгө оруулагчдад Монголд бизнесээ хэрхэн эхлүүлэх боломжтой талаар зөвлөмж, тусламжийг сайн өгөх хэрэгтэй. Би өмнө нь Москвагийн Санхүүгийн томоохон компанид ажиллаж байгаад Монголд томилогдож ирсэн. Анх Улаанбаатарт зөвхөн гар цүнхтэйгээ орж ирсэн. Багахан хүндрэлтэй замыг туулсан л даа. Цахим хуудаснаас мэдээлэл хайсан боловч хангалттай мэдээлэл байхгүй байсан. Улан-Үдэд олон компани Монголын зах зээлд орж ирэхийг хүсч байгаа. Тиймээс тэдэнд мэдээлэл өгөх хэрэгтэй. Гэвч тэдэнд Монголд бизнес эрхлэхэд хангалттай мөнгө байхгүй. Гэтэл Монголын олон бизнес эрхлэгч аль хэдийн Улан-Үдэд бизнесээ эрхлээд эхэлсэн, хэдэн жил амьдарч байгаа хүмүүс ч бий. Энд ирээд харснаар нэг гунигтай зүйл гэвэл Монгол Улс жирийн жуулчинд өртөг ихтэй орон болсон. Санаа зовоож байгаа зүйл нь Монголоос Орос руу жуулчид их явна. Оросоос Монгол руу ховор байна. Өртөг ихтэй гээд. Тиймээс энэ тал дээр анхаарах хэрэгтэй болов үү. ■

ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ



Ц.Элбэгсайхан

Зээлжих зэрэглэл өнөөдрийн нэн чухал сэдэв болж байна. Үндсэндээ 2012 онд Монгол Улс дундаж хөгжилтэй орнуудын эгнээнд шилжсэнээр гадаадын хандив, тусламжаас татгалзаж зах зээлийн зарчмаар хөрөнгө босгох болсноор үүнд ач холбогдол өгөх болсон. Энэ үүднээс анхны бондууд гарч багагүй амжилтад хүрсэн. Өнөөдөр компанийн даатгагдсан бонд хүртэл гараад байна. Харамсалтай нь сүүлийн хоёр жилд манай улсын зэрэглэл буурч ирсэн. Хамгийн сүүлд өнгөрсөн оны долдугаар сард “Moody’s” агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг нэг дэсээр бууруулж “B2” дүн тавьсан юм. Дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн агентлаг болох “S&P” болон “FITCH”-ийн үнэлгээгээр “B+” зэрэглэлтэй. Өмнө нь өсөх хандлагатай, тогтвортой гэгдэж байсан Монголын зээлжих зэрэглэлийн хэтийн төлөвийг “сөрөг” буюу буурах хандлагатай хэмээн дүгнэх болж.

Үндэслэл нь гадаадын хөрөнгө оруулалт эрс багасч өмнөх жилийнх нь төлбөрийн тэнцлийн алдагдал 1.9 тэрбум ам.долларт хүрч гадаад валютын нөөц үлэмж буурсан, том төслүүд зогсонги байдалтай байсан. Ялангуяа Оюутолгой төсөл хэрхэхийг хөрөнгө оруулагчид ажиглаж байгааг тухайн үед агентлагууд тайлбарлаж байв. Дээрх агентлагуудын зөвлөж буйгаар тогтвортой бодлого хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалт татаж, валютын нөөцөө нэмэгдүүлж, макро эдийн засгийн орчноо сайжруулах

хэрэгтэй. Мөн том төслүүдээ хөдөлгөх нь их чухал нөлөөтэй аж.

Таатай мэдээ нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хойш татаж байгаа шалтгаан, дутагдлууд эхнээсээ засарч байна. Тухайлбал, 2013 оны эцэст 2.08 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байсан гадаад худалдааны тэнцэл энэ оны эхний долоон сарын урьдчилсан гүйцэтгэлээр 604 сая ам.долларын ашигтай гарчээ. Гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн оны аравдугаар сарын гүйцэтгэлээр анх 129 сая ам.долларын ашигтай гарснаас хойш тогтмол өсч байгаа билээ. Үр дүнд нь урсгал дансны алдагдал -216 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 904 сая ам.доллараар буюу 5.2 дахин буурсан байна. Хөрөнгө ба санхүүгийн данс 237 сая ам.долларын ашигтай буюу өмнөх оны мөн үеэс 68 сая ам.доллараар нэмэгджээ. Ингэснээр төлбөрийн нийт тэнцэл оны эхний хагаст 83 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 998 сая ам.доллараар сайжирсан байна.

Түүнчлэн Төв банкны гадаад валютын нөөцийн зургадугаар сарын тайланг үзэхэд тухайн сард 5.95 хувь, оны эхнээс 2.16 хувь, өнгөрсөн оны зургадугаар сараас 27.94 хувиар тус тус өсч нийт албан нөөцийн хэмжээ 1.6 тэрбум ам.долларт хүрч. Мэдээнээс харахад сүүлийн гурван сар дараалан гадаад валютын албан нөөц өсөлттэй гарчээ. Энэ бүгд нь макро эдийн засгийн хувьд нааштай дохио болж байна.

Урсгал тэнцлийн алдагдал гэдэг нь энгийн үгээр монголчуудын гадаадад гаргаж худалдаалдаг бараа, үйлчилгээ, шилжүүлгийн орлогоос гаднаас авдаг бараа, үйлчилгээ, шилжүүлгийн төлбөрийн хассан цэвэр дүн. Өөрөөр хэлбэл, монголчууд юуг бүтээж, валютын ямар орлого олов. Юуг гаднаас авч, ямар хэмжээний валютын төлбөр гадагш нь төлөв гэдгийг харуулдаг эдийн засгийн суурь үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт сөрөг утгатай байна гэдэг нь бидний олж байгаа валютын орлого нь гадагш төлдөг валютын хаана ч хүрдэггүй гэсэн үг. 2008-2009 гэсэн хоёр онд энэ үзүүлэлт 1032 сая ам.долларын алдагдалтай байж. Гэтэл 2012-2013 онд 6554 сая ам.доллар хүрч, алдагдал нь 6.4 дахин өсчээ. Бид илүү ихийг гаднаас худалдан авч хэрэглэдэг болсон, харин илүү багыг үйлдвэрлэж, гадагш нь зарж өчүүхэн орлого олж байсан юм.

Одоогоор манай улс хөрөнгө оруулахад эрсдэл багатай орнуудын эгнээнд буй. Түүнчлэн эрсдэл багатай орнуудаасаа нэлээд хойгуурт бичигдэж байна. Харин “AAA” буюу хөрөнгө оруулалтын таатай орчин гэж үнэлэгдвэл хамгийн таатай нөхцлөөр зээл олж чадна. Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мөнхбатын хэлснээр “Зээлжих зэрэглэлийн үнэлгээ нь биднээс хамааралгүй тогтож байдаг тухайн үеийн бодит тусгал байдаг” гэв “Голомт” банкны тэргүүн дэд захирал Л.Болормаагийн үзэж буйгаар зэрэглэлээ сайжруулахад бодлогын

тодорхой, тогтвортой байдал чухал аж. Түүний хэлснээр “Бизнес хийхэд, хөрөнгө оруулахад хэр зэрэг итгэлтэй найдвартай нөхцөл байдал вэ” гэдэг нь зээлжих зэрэглэлийн үндсэн хүчин зүйл бөгөөд “Хөрөнгө оруулагчдын хувьд улс төрийн нөхцөл байдалд нэг их анхаардаггүй” гэсэн юм. Тухайлбал, Казахстан улсад банкуудын муу зээлийн хэмжээ нь 40 хувьтай боловч “BBB” зэрэглэлтэй байгааг тэрээр жишээ болгож байв.

Зэрэглэл өсөх, буурах нь эдийн засагт нөлөөтэй. Хамгийн ойрын жишээ нь дөрвөн хувийн хүүтэй авч байсан Чингис бондыг өнөөдөр зах зээл дээр арилжвал бараг хоёр дахин өндөр хүүтэй авах нөхцөл бий болж байгаа юм. Түүнчлэн бондын эргэн төлөлтийн хугацаа ойртож байгаа. Түүнийг төлөх эх үүсвэр тодорхойгүй байгаа учир бондын хугацааг сунгах нэг хувилбар бий. Энэ нь шинээр бонд гаргахаас нэг их өөрцгүй аж. Нөгөө талаас өндөр хүүтэй бонд худалдан авах нь хөрөнгө оруулагчдад ашигтай ч улсын өрийн хэмжээ нэмэгдэж, зэрэглэл үргэлжлэн буурсаар байвал Монгол Улсаас бонд авах хүн олдохгүй байх эрсдэлтэй. ■

Бондоос гадна дотоодын банкуудын зээлийн санхүүжилт, аж ахуйн нэгжүүдэд ч нөлөө үзүүлдэг. “Хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийн хувьд Засгийн газраасаа бага хүүтэй зээл авах магадлал бараг үгүй. Улсын зэрэглэл буурахад тухайн улсын аж ахуйн нэгжүүдийн авах зээлийн хүү нэмэгдэж байдаг” хэмээн “М-Си-Эс Холдинг” ХХК-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирал С. Цэнгэл тайлбарласан.

Цаашлаад хөрөнгө оруулахад эрсдэлгүй орны эгнээнд багтахад тушаа болж буй нэг томоохон асуудал нь Монголын эдийн засаг нэг салбараас хамааралтай байгаа явдал. Уул уурхайн түүхий эдийн экспорт ДНБ-ий 20 хувийг эзэлж байна. Мөн тус салбарын зээл нь дотоодын банкуудын чадамжийг сулруулж байгааг “Fitch” агентлаг сануулсаар байгаа юм. Тиймээс эдийн засгаа “солонгоруул” гэсэн зөвлөгөөг тэд өгч байна. Үүний дагуу Сангийн дэд сайд С.Пүрэв “Засгийн газрын зүгээс уул уурхайн бус салбарыг хөгжүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх чиглэлээр ажиллаж байна” хэмээсэн.

“Mongolian Economy” сэтгүүлийн асуулт:

-Монголын хөрөнгө оруулалтын орчны талаар та ямар бодолтой явдаг вэ. Засч, залруулах зүйл юу байна вэ?

Жим Двайер: /Монголын Бизнесийн зөвлөлийн гүйцэтгэх захирал/



-Өнөөгийн Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин маш муу байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт эргээд 2009 оны түвшинд хүрсэн байна. Үүнд, хэд хэдэн өөрчлөлт, сайжруулалт шаардлагатай байна.

- Хөрөнгө оруулагчдын хувьд Оюутолгойн далд уурхайг санхүүжүүлсэн, барилгын ажил эхэлснийг харснаар уул уурхайн нийлүүлэлтийн гинжин хэлхээ сэргэж илүү ажлын байр бий болно.

- Тавантолгой гэх мэт бусад мега төслүүдийн ойрын хугацааны хэтийн төлөв хөрөнгө оруулагчдад Монгол Улс бизнес хийхэд нээлттэй байгаа гэж ятгахад тус болно.

- Төрийн өмчит аж ахуйн нэгжийг хувьчлах замаар бизнесийн салбар дахь Засгийн газар болон парламентийн сөрөг нөлөөллийг багасгах.

Энэ онд Монголд хөрөнгө оруулах нь хөрөнгө оруулагчийн хувьд өндөр эрсдэл бүхий асуудал бөгөөд энэ нь ерөнхийдөө Засгийн газрын тогтворгүй байдлаас үүдэлтэй. Монголын Бизнесийн Зөвлөл Монголын урт хугацааны өсөлтийн бололцоонд итгэсээр байгаа юм.

Э.Энэрэлт: /Азийн хөгжлийн банкны Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн/

-Хөрөнгө оруулалтын орчин өнөөдөр тааруу байгааг бүгд мэдэж байгаа учир сайжруулах талаар нэг зүйл хэлье. Хөрөнгө оруулалтын орчинг дэмжих



хэд хэдэн хууль, журмыг төрөөс баталсан. Тухайлбал хууль, эрх зүйн хувьд гадаадын хөрөнгө оруулалтын бүртгэлийг хялбаршуулж, хөрөнгө оруулалтын хэмжээ, газарзүй, салбараас хамаарсан уян хатан татварын урамшуулалын тогтолцоог бүрдүүлсэн. Гол асуудал нь эдгээр зохицуулалтын хэрэгжилт бодит амьдрал дээр хэрхэн явж байна вэ гэдэг юм. Хувийн салбарын хөгжлийг дэмжих төрийн үндсэн үүрэг бол хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдэд хууль эрх зүй, стандарт, татвар, дэд бүтцийн хувьд эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх явдал юм. Урт хугацаанд уул уурхайгаас бусад эдийн засгийн чадавхи бүхий салбаруудыг төрөөс дэмжиж хөгжүүлэх хэрэгтэй.

Монгол Улс хөдөө аж ахуйн баялаг нөөцтэй (2014 онд 51.9 сая толгой мал тоологдсон). Нэг хүнд ногдох махны гарц 80 гаруй кг, сүүний гарц 200 орчим кг байгаа нь дэлхийд дээгүүрт тооцогддог. Монголын үндсэн мал аж ахуй нь бэлчээрийн мал аж ахуй учраас органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжих бүрэн боломжтой. Монголын органик бүтээгдэхүүн нь гадаадын зах зээл дээр өндөр эрэлттэй байна. Иймээс энэ нөөц бололцоог ашиглаад Монголын зарим компаниуд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнээ экспортлож эхэлсэн. Гэвч нөгөө талаас дэд бүтцийн сул хөгжил, тээвэр, хадгалалт, хүнсний ариун цэвэр, эрүүл ахуй, хилийн худалдаанд учирч байгаа саад тотгор нь хөдөө орон нутгийн хөгжлийн гол бэрхшээл болж байна. Дэлхийн өрсөлдөх чадварын 2014-2015 оны тайланд Монгол Улс дэд бүтцийн чанарын хувьд 144 орноос 112, Дэлхийн банкны 2015 оны бизнес хийхэд таатай байдлын талаар хийсэн судалгаагаар хилийн худалдааны хувьд 189 орноос 173 дугаар байранд тус тус жагссан. Эдгээр асуудлыг ээлж дараатай, зохион байгуулалттай шийдсэнээр хөдөө аж ахуйн нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг олон улсад өсгөх боломж өндөр харагдаж байна. Ингэж

чадвал уул уурхайгаас өөр өрсөлдөх чадвар бүхий салбарт хөрөнгө оруулалт татах боломж бүрдэнэ.

СЖ. (Стив) Поттэр: /Вагнер Ази группын Гүйцэтгэх захирал/

-Одоогийн Засгийн газар Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр их зүйл хийсэн гэж боддог. Ялангуяа, хууль эрх зүйн орчны хувьд. Гэсэн хэдий ч Монгол дахь хөрөнгө оруулалтад уул уурхай маш их хамааралтай. Өнөөгийн түүхий эдийн үнийн мөчлөг /нүүрс, зэс, төмрийн хүдэр/ сүүлийн 4-5 жилийн хамгийн доод түвшинд хүрсэн. Мөн төмөр замын дэд бүцийн дутагдлаас болж Хятад болон Азийн бусад орнуудад бүтээгдэхүүнээ үр ашигтайгаар хүргэж чадахгүй байгаа зэрэг нь хөрөнгө оруулагчдыг болгоомжлоход хүргэж байна. Ирэх оны сонгууль хөрөнгө оруулагчдыг хүлээж азнасан байдалтай болгосон бас нэг шалтгаан байж магадгүй. Хэрэв Монголын Засгийн газар Таван Толгойн гэрээний мухардлыг шийдвэрлэж чадвал уул уурхайн хөрөнгө оруулагчдад эерэг мэдээ болж, энэ оны эхэнд Оюутолгойн хоёрдугаар шатны хөрөнгө оруулалтын хэлэлцээрт хүрч чадсанаа зарлах үетэй нэгэн адил байх болов уу.



газар Тавантолгой болон Сентерра Гоулдын Гацууртын төслийг аль болох түргэн хөдөлгөх хэрэгтэй. Би Монгол Улсад анх 2012 оны сонгуулийн өмнөхөн ирж байсан бөгөөд тэр үед энэ улс популизм болон нөөцийг үлдээх үндэсний үзэлтнүүд газар авч байлаа. Тухайн үед авч хэрэгжүүлж байсан бодлого болон арга хэмжээ яах аргагүй хөрөнгө оруулалт болон эдийн засагт их хор хөнөөлтэй байсан. Өнөөдөр улс төрийн мэтгэлцээн хэрхэн хөрөнгө оруулалт татах, мөн эдийн засгаа хэрхэн сэргээх талаар голчлон явагдаж байгаа нь сайн зүйл. Дэлхийн түүхий эдийн зах зээл удааширч байгаа ч сүүлийн үед уул уурхайн төслийг сонирхох нь ихсэх болсон. Энэ нь өнөөгийн Засгийн газрын хөрөнгө оруулалтыг дэмжсэн бодлого, мөн олон нийтийн санаа бодол томоохон төслүүдээ дэмжиж эхэлсэнтэй холбоотой. Хөрөнгө оруулагчдын хувьд ирэх 6-12 сарын хугацаанд Монгол дахь 5-7 жилийн байр сууриа олж авах гайхалтай боломж гэж бодож байгаа.

Т.Хатантуул: /Эдийн засагч/

-Монголын хөрөнгө оруулалтын орчинд дүн шинжилгээ хийхэд гадаад дотоод хүчин зүйлсийг ялгаж авч үзэх хэрэгтэй. Эдийн засгийн зарим бодлого хэр оновчтой байсныг бас бодох хэрэгтэй. Жишээ нь мөнгөний хэт тэлэх бодлого, төсвийн гадуурх энэ олон зардлууд гэх мэт. Ийм нөхцөлд дотоодын хөрөнгө оруулагчид ямарваа нэгэн хөрөнгө оруулалт хийж бизнесээ тэлэх, шинэ төсөл эхлэх, үйл ажиллагаагаа үргэлжлүүлж явна гэдэг нь асуудалтай. Гадаадын хөрөнгө оруулалтын хувьд сүүлийн хоёр жилд бараг жил тутам 50-80 хувиар буурсан. Энэ оны эхний зургаан сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 87 хувиар буурчээ.



Уул уурхайн салбар хөрөнгө оруулалтад маш том үүрэг гүйцэтгэж байгаа. Аливаа хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад өгөөж болон эрсдэл нь чухал хүчин зүйл болдог. Гэтэл өнөөдөр уул уурхайн бүтээгдэхүүний үнийн түвшин болон таамаг хөрөнгө оруулалтын олон шийдвэрт нөлөөлж байгаа. Уул уурхайн салбарт Монголд гэлтгүй гадаад орчинд ч хөрөнгө оруулалтууд буурсаар байна. Гэхдээ Монголын хувьд энэ салбар дахь хөрөнгө оруулалт нь буурсан хамгийн том шалтгааныг үнийн уналтаас гадна дотоодын хууль эрхзүйн болон улс төрийн тогтвортой бус ба тодорхойгүй байдал, мөн хариуцлагагүй сөрөг мессежүүд гэж бодож байна.



Б.Бямбасайхан: /“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал/

-Монголд санхүү, дэд бүтэц, эрчим хүч, уул уурхай гээд суурь салбарт ашигтай бизнесийн боломжууд бий. Өнөөдөр гадаад орчин тааламжгүй, дотоод орчин ойлгомжгүй байгаа нь үнэн. Хувийн өмчийг хэр сайн хамгаалж чадна тэр чинээгээр хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

Гол нь хөрөнгө оруулсан хүн Монголд ашигтай бизнес хийгээд мөнгөө, ашигаа эргүүлж авч чадаж байна уу гэдэг асуудал. Тооцоо судалгаатай, зөв түнштэй, эрсдэлээ зөв хуваарилсан гэрээ хийгээд, ухаалаг менежмент хийвэл Монголд өндөр ашиг хийж болно. Бэрхшээл мэдээж байгаа. Эхнээсээ эрсдэлээ сайн тооцох хэрэгтэй.

Ник Козин: /“БиДиСек” ХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал/

-Миний харж байгаагаар Монголд маш хямд бөгөөд 2016 оны хагас гэхэд эдийн засгийн сэргэлтэд орох өндөр магадлалтай хөрөнгө байна. Энэ сэргэлтэд Оюутолгойн далд уурхайн үйл ажиллагааг дахин эхлүүлэх нь маш их үүрэгтэй боловч энэ нь дан ганцаараа Монгол Улсыг дэлхийн эдийн засагт байх ёстой байранд нь хүргэхэд хүрэлцэхгүй. Засгийн



Уг нь бусад улстай харьцуулахад манай улс татварын таатай орчинтой. Тиймээс улс төр болон хууль эрхзүй нь тогтвортой болон тодорхой байх хэрэгтэй. Гадаад, дотоод гэлтгүй хөрөнгө оруулагчид үүнийг л хүсч байна. Шинээр баталсан Хөрөнгө оруулалтын хууль, хайгуулын салбарыг эргээд нээлттэй болгосон зэрэг нь дунд буюу урт хугацаандаа Монгол Улсад хөрөнгө оруулалтыг татах боломжийг бий болгох чухал алхам. Ингэснээр бид өндөр өгөөж, өндөр эрсдэлийг сонирхох хөрөнгө оруулагчдын анхаарлыг дахиад татах боломжтой гэж бодож байна. ■

Эстони, Ямаик + Африк ба БНХАУ

Ц.Буян

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжээд 20 гаруй жил болж байна. Нээлттэй эдийн засгийн хувьд гадаадын хөрөнгө оруулалт татах нь үргэлж чухал асуудал байдаг. Тэгвэл Монгол Улстай нэгэн зэрэг гарааны шугамаас хөдөлж байсан зарим улс орны хөрөнгө оруулалт татсан туршлагаас хүргэж байна.



Эстони

ЗХУ задран унасны дараа Эстони зах зээлийн эдийн засагт шилжиж маш богино хугацаанд чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалтын орчин бий болгож чадсан юм. 1991 онд тус улсын ДНБ нь 50 хувь хүртэл буурчээ. Гэвч 1990 –ээд оны дунд үед эдийн засаг нь тогтворжиж 2002 он гэхэд нэг хүнд ногдох ДНБ нь 1989 оны үетэй тэнцсэн байна. 1991-2000 он хүртэл хөрөнгө оруулалт эрс нэмэгдсэн байдаг. Үүнд дотоодын хөрөнгө оруулалтын гүйцэтгэсэн үүрэг их байсан ч 2005-2008 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт ихээхэн тэлжээ. Эдийн засгийн өсөлт нь үргэлжилж 2001-2004 онд жилд 7-8 хувь, 2005, 2006 онд 6.3 хувийн өсөлттэй байсан нь тухайн үедээ хамгийн өндөрт тооцогдож байв. Макро эдийн засгийн оновчтой бодлого хэрэгжүүлж 1999 онд Дэлхийн худалдааны байгууллага, 2004 онд Европын холбоонд нэгдсэн юм.

1990-ээд оны эхэнд Эстонид орж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт бараг тэр чигтэй санхүүгийн зах зээл рүү чиглэж байв. Мөн их хэмжээний баялаг агуулдаг салбарууд болох үл хөдлөх хөрөнгө, тээврийн үйлчилгээ, аж үйлдвэр, бөөний болон жижиглэнгийн худалдаанд

их хэмжээний хөрөнгө оруулалт хийжээ. Аж үйлдвэрийн салбарт 1996-1997 онд хийгдсэн хувьчлалтай холбоотойгоор хөрөнгө оруулалт хийгдсэн бол 1998 онд банкны салбар хямралд орсон нь дотоодын банкуудыг нэгдэн нийлэхэд хүргэж, томоохон банкуудыг гадаадын хөрөнгө оруулагчид худалдан авчээ. 2000 оны эхээр худалдан авах чадварын өсөлтийг дагаад бөөний болон жижиглэн худалдаа, үл хөдлөх хөрөнгийн салбарт гадаадын хөрөнгө оруулагчид ач холбогдол өгч эхэлсэн байна. 1990-ээд оны сүүлээр зах зээлд нь гадаадын банкууд орж ирсэн нь 2005 онд тус улсыг чиглэсэн хөрөнгө оруулалтын маш их урсгалыг бий болгож өгөв. Мөн оноос эхлэн, Эстони улсын дотоод гадаадын шууд хөрөнгө оруулалтын гуравны хоёр нь санхүүгийн үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгө, бизнесийн үйлчилгээний салбарт орж байжээ. Ер нь Эстони дахь гадаадын хөрөнгө оруулалтын нэлээд нь ашигтай байсан нь 2002 оноос хойш тус улсад хөрөнгө оруулалтын ихэнх нь хоёрдогч зах зээлээс дахин санхүүжсэн байдгаар нотлогддог. Сонирхолтой нь тус улсын тэргүүлэгч таван компани нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын бараг тал хувийг эзэлдэг байна.



Ямаик

Ямаикын хувьд 1980 –аад онд ардчилалд шилжсэн. Гэвч 1970-аад онд ардчилсан социализм руу шилжсэн байдаг

нь явц их удаан үргэлжилснийг илтгэнэ. 1990-ээд оны эхээр томоохон шинэчлэл хийж бие даасан гадаад худалдаатай

болсон бол 1991 онд валютын үнийг чөлөөлж хөвөгч ханшийг баталгаажуулсан. Ямайк 1962 онд Их Британийн колониос салж парламентын ардчиллын замыг сонгож 1950-аад онд өсөлтийн жилүүдийг үдэж 1960-аад он гарах үед чөлөөт худалдаа, аж үйлдвэр нэлээд хөгжсөн орон болжээ. Гэвч 1972 онд шинэ Засгийн газар импортыг хязгаарлаж, өмч улсын мэдэлд байх ёстой гэж үзсэн юм. Ардчилсан социализм гэгчийг туршсан нь ямайкчуудыг улсаа орхин гарахад хүргэж, түүнийг даган баялаг нь гадагшилж, эдийн засгийн гол салбар аялал жуулчлал зогсонги байдалд оржээ. Харин 1980-аад оны эхээр чөлөөт эдийн засагт шилжсэн юм. Ингээд эдийн засгийн либералчлал өрнөж хувьчлал явагдсан. Хувьчлалын эхэн үед гадаадын хөрөнгө оруулагчид ихэнх хувийг эзэлж байв. 1987-1990 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын 40 хувийг төрийн өмчийн хувьчлал буюу 1970-аад онд төрийн өмчид шилжсэн зочид буудлууд эзэлж байлаа. Мөн 1990-ээд оны сүүлээр зарим банк, 1999 онд Засгийн газрын эзэмшилд байсан Цементийн үйлдвэрийг хувьчилжээ. Энэ үеэс зарим дэд бүтцийн салбарыг гадаадын хөрөнгө оруулагчид хувьчлан авсан байдаг.

Ямайк газар зүйн хувьд Америкийн том зах зээлд ойр оршдог, Спани, Их Британийн колони байсан учир Европын орнуудтай харилцаа сайтай гэсэн давуу талтай байв. Гадаадын хөрөнгө оруулалт нь 1980 аад оны эхээр дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээнээс давж ирсэн бөгөөд 1990 оноос огцом нэмэгджээ. 1991-2002 оныг хүртэл нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 хувийг АНУ дангаараа эзэлдэг. Хөрөнгө оруулалтын гол салбар нь уул уурхай, аялал жуулчлал. Түүнээс гадна 1990-ээд оны сүүлээр хоёрдогч зах зээлээс олох ашиг нь гадаадын хөрөнгө оруулалт татах гурав дахь хүчин зүйл болж өгсөн аж. Энэ үед үнэт цаасны хөрөнгө оруулалт эрс нэмэгджээ. Гэвч үүнээс хойш хоёрдогч зах зээлийн хөрөнгө оруулалт их хэмжээгээр буурч 2008 он гэхэд нийт урсгалын зөвхөн найман хувийг л эзэлж байв. Энэ хугацаанд эдийн засаг нь өссөн боловч 2009 оны хямралын үед авсан зээл нь тус улсыг өрийн асуудалд оруулсан бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээний салбар дахь бүтээмж мууджээ. Сүүлийн үед мэдээлэл, харилцааны технологийн салбарын хөрөнгө оруулалт өсөх хандлагатай байгаа юм.




Африк ба БНХАУ

Хорьдугаар зууны сүүлийн арван жилд Өмнөд Африкийн орнуудад гадаадын шууд хөрөнгө оруулалт их хийгдэж байв. Тэдний зах зээл жижиг, нэг хүнд ногдох ДНБ маш бага байсан ч валютын идэвхтэй ханш, худалдааны орчин, төсвийн тэлэлт нь хөрөнгө оруулалтын урсгал татсан гол хүчин зүйл байсан гэж ОУВС-гийн шинжээчид үзэж байгаа юм. Тус бүс нутагт газрын үнэт баялаг, газрын тосны ордууд илэрсэн нь их хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт татах үндэс болсон. Харин өнөөдөр БНХАУ хөрөнгө оруулалт татах чадвараараа гайхагдаж байна. 2008 онд 100 гаруй тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татсан нь хөгжиж буй орнуудын сүүлийн 10 жилд татсан нийт хөрөнгө оруулалтын 20 хувьтай тэнцдэг. Энэ салбар нь тус улсын нийт хөдөлмөрийн захын 10 хувийг л эзэлдэг аж. 2009 онд

аж үйлдвэрийн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт 81 хувиар өсч, нийт Хөрөнгө оруулалтын хэмжээ 2000 оноос гурав дахин нэмэгджээ. Гадаадын хөрөнгө оруулалтаар аж үйлдвэрийн бүтээмжийг 30 хувь, ашгийг 22 хувь өсгөж чадсан юм.

Хятадын хувьд дотоодын ч бай, гадаадын ч бай компаниудыг ижил түвшинд авч үзэж “тоглолтын талбайг” тэнцүү олгосноороо давуу талтай гэгдэж байгаа юм. Харин өнөөдөр тэдний өмнө тулгарч байгаа гол асуудал нь хөрөнгө оруулалтын урсгалыг зөв татах явдал. Сүүлийн үед хүрээлэн буй орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологийн салбарыг хөрөнгө оруулагчид онилж байгаа юм. ■

Монголын бизнес боломжууд



Э.Зоригт

Хэрвээ та Монголд хөрөнгө оруулахаар шийдсэн ч аль салбарыг сонгохоо мэдэхгүй байгаа бол наашаа анхаарлаа хандуулна уу. Уг нийтлэлээс та бүхэн Монголын уул уурхайгаас бусад салбарт ямар боломж байгааг мэдэх болно.

Барилга

“Үл хөдлөх хөрөнгийн салбарт нь хөрөнгө оруулахад хамгийн тохиромжтой орон бол Монгол” гэж Английн хөрөнгө оруулалтын “Property Frontiers” агентлаг дүгнэжээ. Дүгнэлтээс харахад, барилгын салбарын бүтээн байгуулалтын хэрэгцээ, ялангуяа орон сууцны эрэлт ойрын жилүүдэд эрчимтэй өссөн хэвээр байх нь. Засгаас ипотекийн зээлийн урдчилгааг 10 хувь болгохоо мэдэгдсэн нь гэр хорооллын иргэдийг орон сууцны хороолол руу нүүх боломжийг нээж өгсөн. “Монголын үндэсний барилгачдын холбоо”-ны гаргасан судалгаанаас харахад 1.5-2 тэрбум ам.долларын худалдан авалтын эрэлт байгаа аж. Тиймээс Монголын бизнес боломжийн тэргүүн эгнээнд барилгын салбар явна.

Аялал жуулчлал

Монголд сүүлийн жилүүдэд аялал жуулчлал 10,3-11,7 дахин өссөн нь эдийн засгийн бодит салбаруудаас хамгийн хурдан хөгжиж буй салбар юм. Хүн төрөлхтний соёл иргэншлийн

нэг хэсэг болох нүүдлийн соёлын анх үүссэн болон үлдсэн сүүлчийн голомт болохынхоо хувьд Монгол орон бүхэлдээ аялал жуулчлалыг хөгжүүлэх хамгийн үнэ цэнэтэй нөөц газар. Мөн байгалийн үзэсгэлэнт тогтоц, аж байдал, монгол ахуй зэрэг нь жуулчдыг татдаг. Монгол Улс өнгөрсөн гуравдугаар сард ХБНГУ-ын Берлин хотноо болсон “ITB Berlin 2015” үзэсгэлэнд түнш орноор оролцсон. Энэ үеэр Монгол Улсад жилд дунджаар 400 мянган жуулчин ирдэг бөгөөд энэ тоог, 2016 онд нэг сая 2020 он гэхэд хоёр сая болгох зорилт тавьснаа дэлхий нийтэд зарласан юм. Үүний тулд тусгай аялал жуулчлал тэр дундаа өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд холбогдох яамны зүгээс анхаарч ажиллана гэсэн.

Эрчим хүч

Импортолдог бус экспортолдог орон болох мөрөөдөлтэй монголчууд цахилгаан эрчим хүчнийхээ бараг 80 хувийг дотооддоо үйлдвэрлэж, үлдсэнийг нь гаднаас авчээ. Гэхдээ мөрөөдлийнхөө төлөө хийж байгаа ажил цөөнгүй бөгөөд Эгийн голын цахилгаан станц зэрэг тус салбарт хэрэгжиж байгаа том төсөл олон. Дэлхийн эрчим хүчний балансын 2030 он хүртэлх таамгаас харахад Дэлхийн эрчим хүчний балансын дөрөвний нэг нь Зүүн хойд Азид төвлөрөх тооцоо байна. Монголд нүүрсний 15 сав газрын

хүрээнд хамрагдах 300 гаруй орд илэрсэн. Энэ оны байдлаар 173.3 тонн нүүрсний нөөц байна. Нарийвчилсан хайгуулаар 23.5 тэрбум тонн нөөц батлагдсан. Эрчим хүчний нүүрсний асар их нөөцтэй манай орны хувьд нүүрсний томоохон ордуудаа түшиглэн цахилгаан станц барьж, эхний ээлжинд Хятад болон Зүүн хойд Азийн орнуудад эрчим хүч экспортлох бүрэн боломжтой. Энэ хүрээнд Эрчим хүчний яамнаас Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн 4800 МВт-ын цахилгаан станц барьж, эрчим хүч экспортлох төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Өөр эрчим хүч

Монголын говь бас өөрийн баялгаа гайхуулсаар. Сахарын дараа орох сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй манай говь газар дээрээ ч бас их баялагтай ажээ. Байгальд ээлтэй, шавхагдашгүй нөөц юм. Энэ нөөц азичүүдийн сонирхлыг хэдийнэ татаад эхэлсэн. Хэдийгээр нарийн судалгаа бага ч сэргээгдэх эрчим хүчний нөөц ч Монголын тал нутагт хангалттай байгаа аж. 56.2 тэрбум кВт.цагийн усны, 1200-1400 кВт/метр нарны, 836.8 кВт.цагийн салхины нөөцтэй гэсэн тооцоо байгаа юм.

Аж үйлдвэр

Монгол Улс байгалийн асар их баялагтай бөгөөд гадны улсууд

“Minegolia” гэж нэрлэх нь ч бий. Байгалийн баялгаа эдийн засгийн эргэлтэнд эрчимтэй оруулж байгаа энэ үед уул уурхайн олборлолт нэмэгдэхийн хэрээр түүнийг боловсруулах, нэмүү өртөг шингээх нь чухал болоод байна. Олборлон экспортлох эдийн засгаас аж үйлдвэржсэн эдийн засагтай болох нь Монгол Улсын зорилго юм.

Хүнд үйлдвэрийг цогцолбор байдлаар хөгжүүлэн, эхний ээлжинд нүүрс химийн, зэс, төмөр, цайр зэрэг өнгөт болон хар төмөрлөгийн хүдрийг олборлон анхандундгүн боловсруулалт хийх зориулалттай, дараагийн удаад нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадвартай, байгаль орчинд хор нөлөө багатай орчин үеийн дэвшилтэт технологи бүхий үйлдвэрүүдийг барьж байгуулахаар төлөвлөж байна.

Монгол оронд 80 төрлийн ашигт малтмалын 1000 гаруй орд байдаг. Монгол Улсын ашигт малтмалын тогтоогдсон нөөц:

20.6 тэрбум тонн нүүрс

- 84.1 сая тонн зэс
- 1.08 тэрбум тонн төмөр
- 2.4 мянган тонн алт
- 18.1 сая тонн хар тугалга
- 332,6 сая тонн газрын тос
- Ашигт малтмалын асар их нөөцтэй,

боловсруулах аж үйлдвэр хөгжөөгүй, үйлвэржих үйл явц дөнгөж эхэлж байгаагийн дээр нэмүү өртөг бүтээх боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газрын дэмжлэг их байгаа нь хөрөнгө оруулагчдад томоохон боломж, орон зай юм. Дэлхийн хоёр том зах зээлийн дунд оршдог болон Зүүн хойд Азийн бусад томоохон зах зээлүүдэд ойрхон газар зүйн байрлалтай. Дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжсэнээр дэд бүтэц улам сайжирч байна. Түүнчлэн, Монгол Улс транзит тээврийг хөгжүүлэх чиглэлээр хоёр хөрштэйгөө тохиролцоонд хүрч холбогдох гэрээ хэлэлцээр байгуулсан.

Хөдөө аж ахуй

Тус салбар нь Монгол Улсын уламжлалт салбар бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний 20 орчим хувийг үйлдвэрлэж, хүн амын хүнсний хангамж, үндэсний үйлдвэрийн түүхий эдийн гол түлгүүр болж байгаагийн хувьд үлс

орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн төвшинг тодорхойлох нэг үндэс юм. Улсын нийт ажиллагсдын 35 орчим хувь тухайн салбарт ажиллаж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогоор амьжиргааныхаа үндсэн эх булгийг бүрдүүлж байдаг. Иймд Монгол Улсын төр, засаг хүнс, хөдөө аж ахуйн салбарыг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, бүтээмж үр ашгийг дээшлүүлэх сайжруулахад байнгын анхаарал тавьсаар ирсэн билээ. Хөдөө аж ахуйн салбар нь хүнсний үйлдвэрлэл, мал аж ахуй ба газар тариалан гэх үндсэн салбаруудаас бүрдэнэ. Эдгээрээс мал аж ахуй болон хүнсний үйлдвэрлэлд хөрөнгө оруулагчид хөрөнгөө оруулж өсгөх бүрэн боломжтой гэж үздэг.

Мал аж ахуй

Мал аж ахуйн хөгжлөөс үлс орны эдийн засаг ихээхэн хамааралтай хэвээр байна. Энэ салбараас хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 80 орчим хувийг үйлдвэрлэж, экспортын нийт орлогын 10 орчим хувийг бүрдүүлж байна. Улсын нийт хүн амын гуравны нэг нь зөвхөн мал аж ахуйн орлогоор амьдардаг.

Хүнсний үйлдвэрлэл

Монголын нийт хүнсний бүтээгдэхүүний 70 гаруй хувийг

импортын бараа эзэлдэг. Гэхдээ энэ тоо жил ирэх бүр буурч байгаа бөгөөд монголчууд цаашдаа ч бууруулах зорилготой.

Засгийн газрын зүгээс ч хүнсний үйлдвэрлэлд нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлж хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, үйлчилгээний чанарыг сайжруулах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах зорилт тавин ажиллаж байна. Тус салбарт хөрөнгө оруулах давуу талууд:


-Дэлхийн хоёр том зах зээлийн дунд орших газар зүйн өвөрмөц байршил - үйлдвэрлэл нийлүүлэх боломж.

-Малчдын сонгон үржүүлгийн үр дүнд байгаль-цаг уурын хатуу ширүүн нөхцөлд дасан зохицож, биологийн онцгой шинжийн бүтээгдэхүүн.

-Монгол Улсын нийт ажиллагсдын 35 орчим хувь уг салбарт ажиллаж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогоор амьжиргааныхаа үндсэн эх булгийг бүрдүүлж байдаг.

-Малын тоо тогтмол өссөөр байна. -Чацаргана гэх экологийн эрүүл мэндэд ач тустай шинэ бүтээгдэхүүн бүхий агуулдаг байгаль. ■

Малын тоо, сая толгой, 1918-2014 онд



Малын тоо, хамгийн өндөр үзүүлэлт, мян. толгой



Тогтворжуулах гэрчилгээ

Монгол Улсын УИХ-аар 2011 оны аравдугаар сарын 3-нд баталсан Хөрөнгө оруулалтын тухай болон Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу гадаад,дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих эрх зүйн орчныг тогтворжуулах,хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэхээр тодорхой шалгуур хангасан тохиолдолд тогтворжуулах гэрчилгээ олгохоор заасан байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН 16 ДУГААР ЗҮЙЛД ЗААСНААР:

16.1.1. бизнес төлөвлөгөө,техник эдийн засгийн үндэслэлд заасан хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь энэ хуулийн 16.2,16.3 –т заасан хэмжээнд хүрсэн

16.1.2 хуульд заасан бол байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэсэн байх

16.1.3 тогтвортой ажлын байр бий болгох

16.1.4 дэвшилтэт техник,технологи нэвтрүүлэх шалгууруудыг хангаснаар хөрөнгө оруулагч тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуурыг хангана.

Одоогоор Хөрөнгө оруулалтын газарт хөрөнгө оруулалтын тогтворжуулах гэрчилгээ хүссэн нийт зургаан компани хуулийн дагуу хүсэлтээ ирүүлсэн байгаа бөгөөд үүнээс

Бусад компанийн хувьд тогтворжуулах хүсэлтийн материалуудыг хүлээн авч хянан, үнэлгээ хийж дахин байгуулагдсан хөрөнгө оруулалтын орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын энэ оны дөрөвдүгээр сарын 8-ны өдрийн 89 дугаар захирамжаар Хөрөнгө оруулалтын орон тооны бус зөвлөлийг дахин байгуулсан.

Хуульд зааснаар хууль батлагдахаас өмнөх таван жилийн хугацаанд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын дүнд үндэслэн татварын хувь хэмжээг тогтворжуулах гэрчилгээ олгохоор заасан бөгөөд хөрөнгө оруулалтын дүнг аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайланд үндэслэн тогтооно.

Хөрөнгө оруулалтын бодлого, үнэлгээний хэлтсэсгэрчилгээ хүссэн компаниудын материалуудыг хуулийн дагуу хүлээн авч,бүртгэл хөтлөн хөрөнгө оруулалтын дүнд үнэлгээ хийж байна. Уг хуулиар гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг ижил түвшинд хамгаалж, бодит татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхээр тусгаж өгсөн билээ. Үүний нэг томоохон дэмжлэг нь хуульд заасан тодорхой шалгууруудыг хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд Тогтворжуулах гэрчилгээ олгож, ААНОАТ, НӨАТ, АМНАТ,гаалийн албан татварыг 5-24 жилийн хугацаанд хувь, хэмжээг нь тогтвортой байлгах юм. Одоогийн байдлаар уг гэрчилгээг дотоодын хоёр компани албан ёсоор авсан байна. ■



2015 онд үзэглэсэн Концессын гэрээ

УИХ, Засгийн газраас 2009 онд төр, хувийн хэвшлийн түншлэл болон хамтын ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор “Төр-хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийг батлан гаргаж байв. Ингээд 2010 оны нэгдүгээр сард Концессын тухай хуулийг баталж, 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг гаргасан бөгөөд тус жагсаалтад дэд бүтэц, барилга байгууламж, авто зам, нисэх буудал, эрчим хүч, байгал орчин, боловсрол эрүүл мэнд, спорт аялал жуулчлалын томоохон төслүүд багтсан байна. Эндээс 2015 онд үзэглэсэн Концессын гэрээг танилцуулж байна.

Концессын гэрээ

2015 оны 2-р сар

2

УУЛ УУРХАЙ МЕТАЛЛУРГИЙН ЦОГЦОЛБОР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ КОНЦЕССЫН ГЭРЭЭ
ТУУЛ СОНГИНО УСНЫ НӨӨЦИЙН ЦОГЦОЛБОР ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ КОНЦЕССЫН ГЭРЭЭ
НАРИЙНСУХАЙТ ШИВЭЭХҮРЭН ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТАЙ АВТО ЗАМЫН ТӨСӨЛ ТЭЛМЭНИЙ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨСЛИЙН КОНЦЕССЫН ГЭРЭЭ
БАГА СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЦОГЦОЛБОР ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ КОНЦЕССЫН ГЭРЭЭ

2015 оны 3-р сар

3

АЛТАЙ-ДАРВИ ЧИГЛЭЛИЙН 165 КМ АВТО ЗАМ ТӨСӨЛ
СОНГИНО СУМ-ХЯРГАС НУУРЫН ЗҮҮН ХАЯА ЧИГЛЭЛИЙН 135.5 КМ ХАТУУ ХУЧИЛТАЙ АВТО ЗАМ ТӨСӨЛ
ДАШИНЧИЛЭН-ОРХОНЫ ГҮҮР ЧИГЛЭЛИЙН ЗАМЫН ТӨГСГӨЛӨӨС МӨРӨН-ТАРИАЛАН ЧИГЛЭЛИЙН ЗАМЫН ТӨГСГӨЛИЙГ ХОЛБОХ 112.7 КМ
АЛТАЙ-ДАРВИ ЧИГЛЭЛИЙН 98 КМ АВТО ЗАМ ТӨСӨЛ
БАЯНХОНГОР-АЛТАЙ ЧИГЛЭЛИЙН 129.4 КМ АВТО ЗАМ
МАНДАЛ СУМ (ЗҮҮНХАРАА) ЧИГЛЭЛИЙН 15.8 КМ ХАТУУ ХУЧИЛТАЙ АВТО ЗАМ ТӨСЛИЙН КОНЦЕССЫН ГЭРЭЭ
ТОСОНЦЭНГЭЛИЙН 4 ЗАМЫН УУЛЗВАР-НӨМРӨГ-СОНГИНО ЧИГЛЭЛИЙН 167 КМ АВТО ЗАМ

2015 оны 4-р сар

4

УЛААНБААТАРЫН V ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ
БАГАНУУРЫН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ
РАШААНТ ДАХЬ УЛСЫН НӨӨЦИЙН АГУУЛАХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ КОНЦЕССЫН ГЭРЭЭ

2015 оны 6-р сар

6

БАЯНХОНГОР-АЛТАЙ ЧИГЛЭЛИЙН 126.7 КМ ХАТУУ ХУЧИЛТАЙ АВТО ЗАМ ТӨСӨЛ-ИЙН
БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ (ВТ) КОНЦЕССЫН ГЭРЭЭ

2015 оны 7-р сар

7

ДУУСААГҮЙ БАРИЛГЫГ ЭМНЭЛГИЙН ЗОРИУЛАЛТААР ШИНЭЧЛЭН САЙЖРУУЛЖ, 260 ОР БҮХИЙ НЭГДСЭН ЭМНЭЛГИЙГ
АЖИЛЛУУЛАХ ТӨСӨЛ-ИЙН ШИНЭЧЛЭХ САЙЖРУУЛАХ-АШИГЛАХ-ШИЛЖҮҮЛЭХ КОНЦЕССЫН ГЭРЭЭ
МОНГОЛ УГСААТНЫ ҮНДЭСНИЙ МУЗЕЙН ЦОГЦОЛБОР ТӨСӨЛ-ИЙН УЗРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ-БАРИХ-ӨМЧЛӨХ-АШИГЛАХ
КОНЦЕССЫН ГЭРЭЭ

Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын газар

Хөрөнгө оруулалтын хөтөч

Төв Азийн зүрх хэмээгдэх Монгол Улсад хөрөнгө оруулах гэж буй гадна болоод дотоодын бизнес эрхлэгч та анхаарлаа хандуулна уу. Дэлхийн банкны тайланд манай улс бизнес эрхлэх орчин, эдийн засгийн эрх чөлөөт байдлаараа 189 орноос 25 дугаарт жагсчээ. Түүнчлэн “Форбес” сэтгүүлээр бизнес эрхлэхэд хамгийн таатай улс орнуудын жагсаалтад 54 дүгээрт алхаж явна. Эл үзүүлэлт тэргүүлэгч орнуудтай харьцуулахад хэдий чамлалттай ч Монголын Засгийн газар бизнесийн орчноо илүү сайжруулахын зэрэгцээ улсынхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бодлого барьж буйг энд тэмдэглэе.

Хөрөнгө оруулагч та Монголын бизнесийн орчин хийгээд эл бүс нутагт бизнесээ эхлүүлэхэд мэдээллийн дутмаг байдлаас үүдэлтэй олон саадтай тулгарч байгаа нь дамжиггүй. Таны цагийг хэмнэж, эл бүх асуудлыг тань шийдэхүйц “Хөрөнгө оруулалтын хөтөч” номыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөрөнгө оруулалтын газраас хэвлэснийг уламжилж байна.


Тус ном нь нийт найман бүлэгтэй бөгөөд бусад орны бизнес эрхлэгчид Монголд ирэхийн тулд нислэг болон визний асуудлаа хэрхэн зохицуулах компанийн бүртгэл тэр дундаа

гадаадын компани, түүний төлөөлөгчийн газрыг хэрхэн байгуулах тухай журам зэргийг дэлгэрэнгүй бичсэн байна. Монгол Улс нь Ази, номхон далайн бүс нутагтаа татварын хамгийн бага хувь хэмжээтэй орнуудын тоонд ордогыг ч уг “хөтөч” тайлбарласан байх юм.

Банкны систем, хөрөнгийн зах зээл, газар болон үл хөдлөх хөрөнгийн талаарх мэдээлэл, төрийн байгууллагуудын ажлын цагийн хуваарь, ус, цахилгааны зардал ямар байдаг, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэрэг бизнес эрхлэхэд анхан шатанд хэрэг болохуйц мэдээллийг цогцоор нь тусгажээ. Мөн монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт ойрын жилүүдэд ямар байгаа, аль салбарт түлхүү хөрөнгө оруулалт хийсэн талаар тус хөтөч номоос аваарай.

Сонирхолтой баримт дурьдахад манай улсад ажиллаж буй гаднын иргэдийн дийлэнх нь аж үйлдвэр, удирдлага, хөдөө аж ахуй болон уул уурхайн салбарт ажиллаж байна. Орж ирж буй шууд хөрөнгө оруулалтын дийлэнх нь буюу 73.3 хувь нь геологи хайгуул, уул уурхайн салбарт хийгдэж байгаа аж. ■

Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт салбараар



Эх сурвалж: “Хөрөнгө оруулалтын хөтөч” ном

ТАНИЛЦУУЛГА

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Сэрэлт” ХХК нь “Сэрэлттакс ТМЗ” ХХК-ийг үүсгэн байгуулж Сангийн сайдын 2015 оны хоёрдугаар сарын 16-ны өдрийн 37 тоот тушаалын тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Харилцагчиддаа татвараа хуулийн дагуу үнэн зөв тодорхойлоход нь туслах үндсэн үүрэгтэй манай хамт олон татварын эрх зүйн орчныг тасралтгүй судалж шинжлэн, харилцагчдынхаа үйл ажиллагаанд учирч болох татварын аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, татварын эрсдэлгүй ажиллуулах үндсэн зорилт тавин ажиллаж байна.

Бид харилцагчдаа шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр цаг тухайд нь бүрэн хангах, аливаа эрсдлийг богино хугацаанд арилгах, заавар зөвлөмжийг хууль тогтоомжын хүрээнд хамгийн энгийн ойлгомжтой хувилбараар хүргэхийг зорьж, татварын хуулиудын өөрчлөлт, шинэчлэлүүдийг анхааралтай судалж мэдээллэн ажиллаж байна.

- Нягтлан бодох бүртгэлийн аутсорсинг үйлчилгээ
- Татварын зөвлөх үйлчилгээ
- Бусад зөвлөх үйлчилгээ